

2024



МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАРЫН
ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА





МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАРЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА

2024



АГУУЛГА



1. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....6	7. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН БҮРЭЛДЭХҮҮН.....17
2. 2024 ОНЫ БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН РАНК.....10	* Банкны өрсөлдөх чадварын индекс
* Банкны өрсөлдөх чадварын индекс	* Макро эдийн засгийн хүчин зүйлсийг хасаж тооцсон индекс
* Банкны үр ашигт байдлын индекс	* Бүс нутгийн байршлаарх ангилал
* Банкны эрсдэлийн индекс	* Улсуудын орлогын түвшингээрх ангилал
* Гүнзгийрлийн индекс	* Банкны үр ашигт байдлын индекс
* Хүртээмжийн индекс	* Банкны эрсдэлийн индекс
* Макро эрсдэлийн индекс	* Банкны гүнзгийрлийн индекс
* Хүн амын хөгжлийн индекс	* Банкны хүртээмжийн индекс
* Улс төрийн орчны индекс	* Макро эрсдэлийн индекс
* Мэдээлэл технологийн индекс	* Хүн амын хөгжлийн индекс
3. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН ТАНИЛЦУУЛГА.....11	* Улс төрийн орчны индекс
* Банкны орчин	* Мэдээллийн технологийн индекс
* Зах зээлийн орчин	8. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ.....36
* Хүний хөгжил	* Агрегат индекс тооцох аргачлал
* Дижитал хөгжил	* Дутуу тоон өгөгдлийн тооцоолол
4. БҮС НУТГИЙН ШИНЖИЛГЭЭ.....13	* Индекс тооцоолох томъёонууд
5. УЛС ОРНУУДЫН ОРЛОГЫН ТҮВШНЭЭРХ ШИНЖИЛГЭЭ.....14	9. ИЖИЛТ ТӨСТЭЙ ОРНУУДЫН БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ40
6. МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР..... 15	* Киргизстан
* Банкны өрсөлдөх чадварын индекс / Монгол Улсын эзэлсэн байр/	* Казахстан
* Макро хүчин зүйлсийг хасаж тооцсон банкны өрсөлдөх чадварын индекс / Монгол Улсын эзэлсэн байр	* Узбекистан
	* Индонез
	10. МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР44
	11. БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ.....46

1. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ



Манай Улсын эдийн засаг уул уурхайн салбарын идэвхжилийн үе, мөчлөгийн дараах банкны салбарын тэлэлт, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа зэргээс ихээхэн хамаарч ирсэн бөгөөд дээрх гурван салбарын хувьд эдийн засгийн голлох ачааг нуруун дээрээ үүрсээр иржээ. Эдгээрээс банкны салбарын хувьд эдийн засгийн мөнгөний эргэлтийг зохицуулдаг, зуучлагчийн үүргийг гүйцэтгэж буй тул тулгарах асуудлууд нэлээдгүй байдаг.

Сүүлийн жилүүдэд технологийн дэвшлийн нөлөөгөөр санхүүгийн салбар тэр дундаа банкны салбар нь асар хурдацтайгаар дижитал шилжилтийг эрчимтэй хийж бүхий л үйл ажиллагаандаа технологийн шинэчлэлийг ашиглахад ихээхэн анхаарлаа хандуулж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын хүүгийн түвшин өндөр улсуудын дотор байна. Тухайлбал, сүүлийн 10 жилийн дундаж зээлийн хүүгийн түвшин, хадгаламжийн хүүгийн түвшин болон инфляцын түвшингээр дэлхийн хэмжээнд эхний 15 дотор байсаар иржээ.

Манай Улсын Их Хурлаас 2020 онд зээлийн хүүг бууруулах стратеги баталж хууль, эрх зүйн шинэчлэлт хийхээс гадна, макро эдийн засгийн орчинг тогтвортой байхад чиглэсэн арга хэмжээ авч ажилласан хэдий ч цар тахлын нөхцөл байдал болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан зээлийн хүүг хангалттай хэмжээнд бууруулж чадаагүй бөгөөд цаашид ч зээлийн хүүг хэрхэн бууруулах, банкны салбарын өрсөлдөх чадварыг хэрхэн нэмэгдүүлэх, бүс нутагтаа санхүүгийн зах зээлийн томоохон бүс болоход юу шаардлагатай вэ гэдгийг дахин тодорхойлох хэрэгцээ шаардлага гарч ирсэн.

Ийнхүү дээрх асуултад хариулт авахын тулд бид уул уурхайд суурилсан эдийн засгийн орнууд, бүс нутгийн орнууд, орлогын түвшин ижил орнуудтай

өөрсдийн эдийн засаг, банкны салбарыг харьцуулан судалж оновчтой гаргалгаа гаргах нь чухал юм.

Судалгааны эхний хэсэгт, Банкны өрсөлдөх чадварын индексээр түүвэрт сонгогдсон улсуудын ранкийг гаргасан. Тус хэсгээс нэгдсэн индекс, түүний бүрэлдэхүүн болох дэд индексээр улс орнуудын жагсаалтыг харах боломжтой. Түүнчлэн, банкны өрсөлдөх чадварын индекс тооцох арга аргачлал, бүрэлдэхүүн хэсгийн үзүүлэлтийг хэрхэн сонгосныг энэ бүлгээс унших боломжтой.

Судалгааны түүврийг сонгохдоо уул уурхайд суурилсан эдийн засагтай (Уул уурхай, Металлын Үндэсний Зөвлөлөөс гаргасан) орнууд, бүс нутгийн орнууд, орлогын түвшин ижил орнуудыг (Дэлхийн банкны ангилал) голчлон авч үзсэн бөгөөд нийтдээ 37 улсыг судалгаанд хамруулсан.¹

Банкны өрсөлдөх чадварын индексээр Монгол улс нь 2019 онд 37-н улсаас 28-д байсан бол 2024 оны судалгаагаар 9-р байранд бичигдэж 18 байр урагшилжээ. Бүс нутгийн 5 орноос 1-р байр, уул уурхайн хамаарал бүхий 21 орноос 6-р байр, дунджаас дээгүүр орлоготой 14 улсаас 3-р байрыг тус тус эзэлж өмнө хийж байсан судалгаатай харьцуулахад банкны салбарын өрсөлдөх чадвар эрс сайжирчээ.

Харин банкны өрсөлдөх чадварын индексээс макро орчны хүчин зүйлийг хасаж тооцоход (инфляц, гадаад өрийн үзүүлэлт гэх мэт) үр дүн нэлээд анхаарал татав. Тодруулбал, тус индексээр Монгол улс 37 улсаас 3-р байр, Бүс нутгийн 5 орноос 1-р байр, уул уурхайн хамаарал бүхий 22 орноос 2-р байр, дунджаас дээгүүр орлоготой 14 улсаас 1-р байрыг тус тус эзэлжээ.

¹ Өмнөх өрсөлдөх чадварын судалгаагаар нийтдээ 39 улсын тоон мэдээллийг ашиглаж байсан бол энэ удаа геополитикийн хурцадмал байдалтай байгаа 2 улсын мэдээллийг оруулаагүй.

Өөрөөр хэлбэл, макро орчны тогтворгүй байдал манай улсын банкны салбарын өрсөлдөх чадварт хүчтэй нөлөөлж байна. Монгол ч гэлтгүй хөгжиж буй орнуудын хувьд, макро эдийн засгийн тогтворгүй байдал өндөр, улс төрийн орчин таагүй дүр зураг ажиглагдаж байна.

Банкны өрсөлдөх чадварын индексийн дэд бүлгүүд дээрх индексээр Монгол улсын хувьд, банкны салбарын хүртээмж, гүнзгийрлийг илэрхийлэх үзүүлэлтээр харьцангуй дээгүүр бичигдэж байна. Түүнчлэн улс төрийн орчин, хүний хөгжил, мэдээлэл технологийн индексээр эхний 20 байранд багтаж байна. Харин банкны салбарын үр ашиг, эрсдэл, макро эдийн засгийн тогтвортой байдлын индексээр дээгүүр бичигдэж эхэлжээ.. Тус тайланд дэд индекс бүрийн хажуу нүүрэнд тухайн индекстэй холбогдох үзүүлэлтийг Монгол улсын хувьд тодорхойлон авч үзсэн. Тухайлбал, мэдээлэл технологийн индексийн хажуу нүүрнээс та бүхэн дижитал банкны үйлчилгээний талаарх харилцагчийн чиг хандлагыг тодорхойлсон судалгааг унших боломжтой.

Индексэд интернэтийн хэрэглээ болон цахим банкны үйлчилгээтэй холбоотой мэдээллийг нэмэлтээр Монголбанк хөдөлгөөнт банкны тайлан болон Үндэсний статистикийн хорооны холбоо харилцааны салбарын тайлан мэдээнээс холбогдох тоон мэдээллийг оруулсан.

Түүнээс гадна, индексэд ашиглагдсан 18-н үзүүлэлтүүд нь яагаад банкны өрсөлдөх чадварыг илэрхийлэх талаар онолын тайлбар, тодорхойлолтыг мөн унших боломжтой. Тус тайланд хэд хэдэн онцлог судалгаануудыг дотроо багтаасан. Тухайлбал, банкны салбар нь санхүүгийн зах зээлийн дийлэнх хувийг эзэлдэг, орлогын түвшин ижил Киргизстан, Казахстан, Узбекистан болон Индонез 4 улсыг сонгон, банкны салбарын орчны судалгааг хийсэн.

Судалгааны зарим сонирхолтой үр дүнгээс дурдвал, сүүлийн жилүүдэд тухайн улсууд банкны салбарын дижиталжилтад ихээхэн анхаарал хандуулж, тэр хэмжээгээр хөрөнгө оруулалтыг эрчимтэй хийж байна. Тухайлбал, Казахстан болон Киргизстан улсуудын хувьд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээг хэрэглэгч бүрд хүргэхэд анхаарлаа хандуулж дижитал банк, финтекүүдийг

эрчимтэй дэмжих зорилгоор хууль, эрх зүйн өөрчлөлтүүдийг эрчимтэй хийж байна. Сонгосон улсуудын хувьд сүүлийн жилүүдэд чанаргүй зээлийн хэмжээг бууруулахад ихээхэн анхаарал хандуулж, тэр хэмжээгээр чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурчээ.

Харин дараагийн онцлох судалгаа нь Монгол улсын өрсөлдөх чадварыг тоймлон авч үзсэн. Тус шинжилгээнд, Дэлхийн өрсөлдөх чадварын төвөөс гаргасан Өрсөлдөх чадварын судалгааг ашигласан.² Энэхүү судалгаанд 67 улсыг хамруулдаг бөгөөд манай улс 61-р байранд эрэмбэлэгдэж өмнөх оноос 1 байраар урагшилсан.

Эдийн засаг харьцангуй тогтвортой өсөлттэй буй хэдий ч гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны төрөлжилт бага байгаа нь эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэл өндөр тул индексийн утгад сөргөөр нөлөөлжээ.

Засгийн газрын үр ашигт байдал, тэр дундаа бизнесийн орчинг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээ дутмаг байгаа нь индексийн утгад сөргөөр нөлөөлжээ.

Хөдөлмөрийн зах зээл үр ашигт байдал бага, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэхгүй байгаа нь бизнесийн үр ашигт байдлын индексэд сөргөөр нөлөөлсөн.

Хүн амын эрүүл амьдрах, тасралтгүй найдвартай боловсрол олгох, технологийн шинэчлэлийг ашиглах дэд бүтцийн ажлууд дутмаг хийгдэж байгаа нь дэд бүтцийн индекс болон ерөнхий индексийн утгад сөргөөр нөлөөлжээ.

Энэ нь бидний тооцсон индексийн хандлагатай ч таарч байгаа юм. Банкны өрсөлдөх чадварын индексийг манай эдийн засгийн тогтворгүй орчин хамгийн ихээр доош татаж байв.

Сүүлийн онцлох судалгаа нь банкны салбарын тойм судалгаа юм. Манай улсын банкны салбар нь сүүлийн 5 жилийн хөгжлийн хандлага үр ашигт байдлыг харуулахыг зорьсон. Тус судалгаанаас 2019 онтой харьцуулахад банкны салбар 2024 онд хэрхэн ажилласан, үйл ажиллагаа өргөжүүлэхэд ямар хүчин зүйлс нөлөөлсөн талаар дэлгэрэнгүй харах боломжтой юм.

² Энэхүү судалгаа нь хамгийн сүүлд 2024 онд гаргасан

2. 2024 ОНЫ БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН РАНК

Банкны өрсөлдөх чадвар нь банкны үр ашиг, эрсдэл болон санхүүгийн зуучлал, хүртээмж зэрэг салбарын дотоод хүчин зүйлсээс хамаарахаас гадна макро эдийн засгийн тогтвортой байдал, улс төрийн орчин, хүний болон технологийн хөгжил зэрэг гадаад хүчин зүйлсээс мөн шалтгаална. Эдгээр хүчин зүйлсээс хамаарч банкны салбарын хөгжих орон зай бий болж, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

**БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН
ИНДЕКС**

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Чили	14
	2	Саудын Араб	0
	3	Австрали	5
	4	Канад	8
	5	Бразил	-4
	6	АНЭУ	-2
	7	Катар	-2
	8	Доминик	-1
	9	Монгол	19
	10	Мексик	-7
	11	Казахстан	12
	12	Индонез	-1
	13	Армен	7
	14	Унгар	-1
	15	Перу	-9
	16	Намиби	1
	17	Турк	-3
	18	Зимбабве	0
	19	Тажикстан	0
	20	Ботсвана	-10
	21	Узбекистан	0
	22	Колумб	-13
	23	Киргизстан	10
	24	Филиппин	6
	25	Боливи	0
	26	Хятад	-5
	27	Энэтхэг	3
	28	Вьетнам	-3
	29	Өмнөд Африк	-14
	30	Гана	-4
	31	Марокко	0
	32	Мадагаскар	-9
	33	Конго, Дем	0
	34	Камерун	2
	35	Судан	-1
	36	Сенегал	-1
	37	Пакистан	0

**Бүрэлдэхүүн индекс 1: БАНКНЫ ҮР
АШИГТ БАЙДЛЫН ИНДЕКС**

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Киргизстан	22
	2	Мадагаскар	-1
	3	Судан	1
	4	Гана	1
	5	Казахстан	33
	6	Ботсвана	7
	7	Монгол	28
	8	Мексик	-6
	9	Зимбабве	-3
	10	Намиби	-1
	11	Доминик	-1
	12	Бразил	-1
	13	Перу	4
	14	Камерун	-7
	15	Сенегал	-12
	16	Индонез	-2
	17	Тажикстан	-1
	18	Унгар	0
	19	Саудын Араб	1
	20	Колумб	-1
	21	Филиппин	10
	22	Өмнөд Африк	-14
	23	Конго, Дем	-1
	24	Боливи	-3
	25	Катар	1
	26	АНЭУ	2
	27	Чили	5
	28	Энэтхэг	9
	29	Вьетнам	-4
	30	Австрали	3
	31	Узбекистан	-16
	32	Канад	-5
	33	Турк	-21
	34	Пакистан	-6
	35	Армен	0
	36	Хятад	-13
	37	Марокко	-8

**Бүрэлдэхүүн индекс 2: БАНКНЫ
ЭРСДЭЛИЙН ИНДЕКС**

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Армен	10
	2	Саудын Араб	1
	3	Чили	26
	4	Доминик	0
	5	Зимбабве	2
	6	Индонез	2
	7	Киргизстан	5
	8	Пакистан	29
	9	Канад	21
	10	Турк	17
	11	АНЭУ	3
	12	Бразил	-10
	13	Боливи	15
	14	Филиппин	-9
	15	Австрали	16
	16	Гана	-7
	17	Узбекистан	-5
	18	Унгар	2
	19	Казахстан	-5
	20	Монгол	5
	21	Энэтхэг	12
	22	Мексик	-4
	23	Тажикстан	-2
	24	Конго, Дем	-2
	25	Намиби	-2
	26	Катар	-2
	27	Судан	-11
	28	Колумб	-11
	29	Перу	-29
	30	Ботсвана	-25
	31	Камерун	0
	32	Мадагаскар	-17
	33	Хятад	2
	34	Өмнөд Африк	-2
	35	Вьетнам	-16
	36	Марокко	1
	37	Сенегал	-3

■ Европ болон Австрали

■ Зүүн Ази ба Номхон далай

■ Хойд болон Өмнөд Америк

■ Төв Ба Өмнөд Ази

■ Ойрх Дорнод ба Хойд Африк

■ Сахарын Өмнөд Африк

Бүрэлдэхүүн индекс 3. ГҮНЗГИЙРЛИЙН ИНДЕКС

Бүрэлдэхүүн индекс 4. ХҮРТЭЭМЖИЙН ИНДЕКС

Бүрэлдэхүүн индекс 5. МАКРО ЭРСДЭЛИЙН ИНДЕКС

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Канад	0
	2	Хятад	0
	3	Чили	0
	4	Австрали	0
	5	Өмнөд Африк	0
	6	Вьетнам	0
	7	Марокко	0
	8	Бразил	0
	9	Боливи	1
	10	Армен	1
	11	Энэтхэг	1
	12	Филиппин	10
	13	Турк	1
	14	Перу	9
	15	Катар	0
	16	АНЭУ.	0
	17	Намиби	0
	18	Саудын Араб	0
	19	Узбекистан	0
	20	Монгол	0
	21	Сенегал	-1
	22	Колумб	-9
	23	Мексик	-2
	24	Казахстан	11
	25	Ботсвана	0
	26	Зимбабве	0
	27	Унгар	0
	28	Индонез	0
	29	Доминик	0
	30	Тажикстан	0
	31	Пакистан	0
	32	Киргизстан	0
	33	Судан	0
	34	Камерун	0
	35	Гана	1
	36	Мадагаскар	1
	37	Конго, Дем	0

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Канад	0
	2	Монгол	0
	3	Узбекистан	1
	4	Армен	1
	5	Австрали	-3
	6	Бразил	0
	7	Казахстан	0
	8	Турк	3
	9	Мексик	1
	10	Боливи	4
	11	Марокко	4
	12	Хятад	7
	13	Колумб	9
	14	Перу	6
	15	Чили	-7
	16	Өмнөд Африк	7
	17	Пакистан	14
	18	Энэтхэг	6
	19	Киргизстан	8
	20	Филиппин	8
	21	Ботсвана	8
	22	Гана	14
	23	Вьетнам	9
	24	Сенегал	9
	25	Судан	9
	26	Камерун	9
	27	Мадагаскар	10
	28	Тажикстан	-12
	29	Унгар	-22
	30	Доминик	-13
	31	Конго, Дем	-1
	32	Намиби	-21
	33	Индонез	-21
	34	Катар	-14
	35	АНЭУ.	-10
	36	Зимбабве	-10
	37	Саудын Араб	-22

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Чили	28
	2	Перу	12
	3	Ботсвана	2
	4	Катар	2
	5	Саудын Араб	2
	6	Колумб	3
	7	Конго, Дем	4
	8	Зимбабве	4
	9	Мексик	1
	10	Камерун	10
	11	Вьетнам	16
	12	Австрали	9
	13	Доминик	3
	14	Индонез	3
	15	Узбекистан	17
	16	Турк	17
	17	Тажикстан	2
	18	Армен	16
	19	Канад	16
	20	Намиби	2
	21	Монгол	15
	22	Энэтхэг	-20
	23	Мадагаскар	-20
	24	Киргизстан	4
	25	Судан	-1
	26	АНЭУ.	-1
	27	Унгар	-1
	28	Филиппин	-24
	29	Өмнөд Африк	-6
	30	Бразил	-29
	31	Сенегал	-2
	32	Марокко	-2
	33	Казахстан	3
	34	Боливи	-22
	35	Хятад	-21
	36	Пакистан	-29
	37	Гана	-20

■ Европ болон Австрали
■ Зүүн Ази ба Номхон далай

■ Хойд болон Өмнөд Америк
■ Төв Ба Өмнөд Ази

■ Ойрх Дорнод ба Хойд Африк
■ Сахарын Өмнөд Африк

Бүрэлдэхүүн индекс 6. ХҮН АМЫН
ХӨГЖЛИЙН ИНДЕКС

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Хятад	11
	2	Чили	-1
	3	Мексик	-1
	4	Казахстан	-1
	5	Канад	-1
	6	Австрали	0
	7	Катар	0
	8	Армен	3
	9	АНЭУ	0
	10	Монгол	8
	11	Бразил	-1
	12	Колумб	1
	13	Перу	1
	14	Саудын Араб	1
	15	Унгар	1
	16	Узбекистан	9
	17	Вьетнам	12
	18	Доминик	0
	19	Турк	-15
	20	Ботсвана	-13
	21	Индонез	-1
	22	Намиби	-1
	23	Тажикстан	-1
	24	Зимбабве	-1
	25	Конго, Дем	-1
	26	Боливи	0
	27	Марокко	0
	28	Энэтхэг	3
	29	Филиппин	-1
	30	Өмнөд Африк	-11
	31	Киргиз Улс	-1
	32	Пакистан	0
	33	Сенегал	0
	34	Судан	0
	35	Камерун	0
	36	Гана	0
	37	Мадагаскар	0

Бүрэлдэхүүн индекс 7. УЛС ТӨРИЙН
ОРЧНЫ ИНДЕКС

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	Чили	0
	2	Канад	0
	3	Австрали	0
	4	АНЭУ	0
	5	Казахстан	1
	6	Вьетнам	9
	7	Унгар	0
	8	Катар	0
	9	Хятад	-4
	10	Марокко	7
	11	Ботсвана	-1
	12	Намиби	-1
	13	Армен	-1
	14	Саудын Араб	-1
	15	Гана	-6
	16	Колумб	5
	17	Сенегал	1
	18	Узбекистан	4
	19	Индонез	1
	20	Доминик	3
	21	Монгол	3
	22	Турк	-6
	23	Тажикстан	2
	24	Энэтхэг	2
	25	Өмнөд Африк	-11
	26	Перу	-7
	27	Мексик	0
	28	Зимбабве	0
	29	Бразил	3
	30	Киргизстан	4
	31	Боливи	2
	32	Конго, Дем	-2
	33	Филиппин	-2
	34	Мадагаскар	-5
	35	Пакистан	0
	36	Судан	0
	37	Камерун	0

Бүрэлдэхүүн индекс 8. МЭДЭЭЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ИНДЕКС

Бүс нутаг	2024 онд	Улс	2019 онтой харьцуулбал
	1	АНЭУ	0
	2	Канад	0
	3	Австрали	10
	4	Чили	-1
	5	Казахстан	-1
	6	Катар	0
	7	Марокко	-1
	8	Монгол	21
	9	Узбекистан	10
	10	Саудын Араб	0
	11	Бразил	1
	12	Армен	-11
	13	Киргиз Улс	13
	14	Мексик	0
	15	Турк	-9
	16	Вьетнам	0
	17	Ботсвана	12
	18	Унгар	0
	19	Доминик	0
	20	Индонез	0
	21	Намиби	0
	22	Зимбабве	0
	23	Боливи	1
	24	Хятад	1
	25	Колумб	-12
	26	Филиппин	11
	27	Өмнөд Африк	-12
	28	Перу	0
	29	Тажикстан	0
	30	Конго, Дем	0
	31	Пакистан	0
	32	Сенегал	0
	33	Энэтхэг	0
	34	Судан	0
	35	Камерун	0
	36	Гана	-10
	37	Мадагаскар	0

■ Европ болон Австрали
■ Зүүн Ази ба Номхон далай

■ Хойд болон Өмнөд Америк
■ Төв Ба Өмнөд Ази

■ Ойрх Дорнод ба Хойд Африк
■ Сахарын Өмнөд Африк

3.БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕСКИЙН ТАНИЛЦУУЛГА



Олон улсын түвшинд банкны өрсөлдөх чадвар, төвлөрлийн талаарх судалгааны ажил их байдаг ч банкны өрсөлдөх чадварын индекс тооцсон судалгаа, товхимол, тайлан ховор.

Харин олон улсын түвшинд улсуудын өрсөлдөх чадварын индексийг Дэлхийн Эдийн Засгийн Форумаас тооцдог бөгөөд дэд бүлэгт нь санхүүгийн системийн өрсөлдөх чадварыг багтаан авч үздэг. Тиймээс банк, даатгал, хөрөнгийн зах зээлээр тухайн улсын санхүүгийн системийн өрсөлдөх чадвар нь тодорхойлогддог гэж ойлгож болно.

2020 онд Монголын Банкны Холбооноос банкны өрсөлдөх чадварыг тодорхойлох зорилгоор банкны өрсөлдөх чадварын индексийг анхлан тооцон гаргасан. Энэ удаагийн банкны салбарын өрсөлдөх чадварын судалгаагаар өмнө тооцож байсан индексийн аргачлалыг сайжруулан 4 жилийн дараа дахин тооцож байна.

Энэхүү тайлан нь 2020 онтой харьцуулбал эдийн засаг, хүн ам зүй, улс төрийн нөхцөл байдал, технологид ямар өөрчлөлтүүд гарсан тэр нь эргээд банкны салбарын өрсөлдөх чадварт хэрхэн нөлөөлснийг харьцуулан харах боломжийг бүрдүүлж өгч буй юм.

Тус судалгаа нь банкнуудын хувьд, олон улсын түвшинд хаана явж байгаагаа мэдэх боломжийг олгох бол харилцагч, олон нийтэд банкны салбарын үйлчилгээ, хүртээмж ямар түвшинд байгааг харьцуулан харах боломжийг тус тус нээж өгч байгаа юм.

Хөрөнгө оруулагчдын хувьд цаашид банкны салбарт хөрөнгө оруулах нь хэр үр ашигтайг тооцоолох, банкны салбарын өсөлт хөгжил, санхүүгийн үр нөлөөллийн талаарх мэдээллийг олж авах боломжтой юм.

Нөгөө талаас эрх баригч, бодлого боловсруулагчдад банкны салбарын хөгжилд макро эдийн засаг, улс төрийн орчин хэрхэн нөлөөлж буйг харах нөхцөлийг бүрдүүлж өгч буйгаараа онцлог юм.

Банкны өрсөлдөх чадварын индексийг тооцохдоо банкны салбарын дотоод хүчин зүйл болох банкны үр ашиг, олон нийтэд хүртээмжтэй байдал, улс орны эдийн засгийг дэмжиж буй байдал зэргээр тодорхойлсон. Гадаад хүчин зүйлийг макро эдийн засаг, улс төрийн орчин, хүн амын хөгжил, техник технологийн дэвшил зэрэг үзүүлэлтүүдийг сонгон авсан.

Сүүлийн жилүүдэд мэдээлэл технологийн салбар хөгжихийн хэрээр хүмүүсийн амьдралын хэв маяг асар хурдацтайгаар өөрчлөгдөж байна. Тиймээс хүн амын хөгжил, техник технологийн дэвшлийг заавал оруулж тухайн улс орон хэрхэн технологийн дэвшлийг санхүүгийн зах зээл тэр дундаа банкны салбарт ашиглаж байна вэ гэдгийг харуулах нь чухал ач холбогдолтой юм.

Судалгааны түүврийг сонгохдоо дараах 3 нөхцөл байдлыг харгалзан авч үзсэн. Нэгдүгээрт, Монгол улс нь байгалийн баялагтай, уул уурхайгаас хамаардаг орон тул тус онцлогийг шингээсэн 21 улс орныг сонгосон. Хоёрдугаарт, Монгол улс нь дунджаас дээгүүр орлоготой орон тул мөн л ижил түвшний орлоготой улсуудыг сонгон тэдгээр улсуудтай харьцуулахад манай улсын банкны салбарын хөгжил ямар түвшинд явааг харуулахыг зорьсон.³ Гуравдугаарт, бүс нутгийн хэмжээнд харьцуулж болохуйц орнуудыг сонгон, банкны салбарын хөгжил ямар түвшинд байгааг харуулах, цаашлаад банкны салбарын өрсөлдөх орон зай хаана байгааг харуулах, өрсөлдөх чадвараа хэрхэн нэмэгдүүлэх боломжтойг үзүүлэхийг зорьж улс орнуудыг сонгосон.

³Дэлхийн банкны ангиллаар манай улсын эдийн засаг 2022 оноос тасралтгүй өссөн нь нөлөөлж 2024 онд дахин дундаас дээгүүр орлоготой орны ангилалд орж ирсэн

Банкны өрсөлдөх чадварын индекс нь дотроо 8 багана индекс, 18 үзүүлэлтийг агуулж байна. Эдгээрт банкны салбарын үзүүлэлтүүд болох үр ашиг, эрсдэл, гүнзгийрэл, хүртээмжийн үзүүлэлтүүд хамрагдаж байгаа бол нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдэд макро эдийн засгийн эрсдэл, хүн амын хөгжлийн үзүүлэлтүүд түүнчлэн засгийн газрын тогтвортой байдлын үзүүлэлтүүд, дээр нь мэдээллийн технологийн үзүүлэлтүүдийг дэд бүлэгт хамруулан тооцсон.

БАНКНЫ ОРЧИН

	Багана 1 БАНКНЫ ҮР АШИГТ БАЙДАЛ
	Багана 2 БАНКНЫ ЭРСДЭЛИЙН ТҮВШИН
	Багана 3 БАНКНЫ САЛБАРЫН ГҮНЗГИЙРЭЛ
	Багана 4 БАНКНЫ ЗУУЧЛАЛ

ХҮНИЙ ХӨГЖИЛ

	Багана 5 ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
---	--

Бүс нутгийн онцлогийг харуулах зорилгоор Зүүн Ази, Номхон далайн улсуудаас түүврээ сонгосон талаар өмнөх хэсэгт дурдсан.

Улмаар нийтдээ 37 улсыг судалгаандаа хамруулсан болно. Үзүүлэлтүүдийн тоо мэдээллийн эх үүсвэрийг сонгохдоо Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан, улс орнуудын Төв банкууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын дата баазыг ашиглан тоон мэдээллийг шинжлэн боловсруулав.

Бид индексийг тооцохдоо Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) нийлмэл хувьсагч боловсруулах аргачлалыг ашиглан боловсруулсан нь индексийн шат дараа болон шалгуурууд нь олон улсад нийцтэй, бодит индекс боловсруулахад ихээхэн тус нэмэр болж, олон улсын үзүүлэлтүүдийг харьцуулахад шаардагдах тоон өгөгдлийн дутмаг байдлыг хамгийн үнэнд ойр байхуйцаар үнэлэхэд шаардагдах онолын хөтөч болсон юм. Түүнчлэн,

индексийг цаашид боловсруулахад нэгдсэн шатлалын дагуу тооцох боломжийг бүрдүүлж буйгаараа давуу талтай юм.

Индексэд ашигласан үзүүлэлтүүд нь богино хугацааны банкны өрсөлдөх чадварыг илтгэнэ. Учир нь нэг жилийн дотор банкны салбарын үр ашигт байдал, эрсдэл, гүнзгийрэл өөрчлөгдөх боломжтой.

ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

	Багана 6 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН
	Багана 7 УЛС ТӨРИЙН ОРЧИН

ДИЖИТАЛ ХӨГЖИЛ

	Багана 8 МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ
--	--------------------------------

Дээр нь технологийн дэвшлийн нөлөөгөөр санхүүгийн салбар тэр дундаа банкны салбарын уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээ улам бүр өөрчлөгдөж тэр хэмжээгээр банкны салбарын үр ашигт байдал даган хувьсаж байна.

Мөн технологийн компаниуд, технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэгч банк бус санхүүгийн байгууллагууд асар хурдацтайгаар санхүүгийн зах зээлд нэвтэрч хурдан шуурхай, зардал багатай бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож буй нь банкны салбарын өрсөлдөх чадварт ч нөлөөлж байна.

Индексийг тооцохдоо банкны салбарын хууль эрх зүйн орчин, татварын орчин болон бус холбогдох хуулийн талаар оруулаагүй. Учир нь улс бүрийн татварын хууль болон холбогдох, эрх зүйн онцлог нь харилцан адилгүй байгаа нь тооцоололд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзсэн.

4. БҮС НУТГИЙН ШИНЖИЛГЭЭ

Сонгогдсон 37 орнуудыг бүс нутгаар нь харьцуулав. 2020 оны өрсөлдөх чадварын судалгаагаар Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг дахь орнуудын банкны өрсөлдөх чадварын индексийн зөрүү бага байсан бол **2024 онд Төв Азийн орнууд болон Ойрх Дорнодын бүс нутгийн индексийн зөрүү харьцангуй багасаж иржээ.** Ойрх Дорнодын бүс нутгийн хувьд өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд өмнөх удаагийнхтай харьцуулахад буурсан нь индексийн зөрүү багасахад нөлөөлжээ.


Төв болон Өмнөд Азийн бүс нутгийн орнуудын хувьд индексийн зөрүү харьцангуй тогтвортой байна. Сахарын Өмнөд Африкийн хувьд индексийн зөрүү өндөр хэвээр байгаа бол Америк тивийн нутгийн хувьд, индексийн зөрүү харьцангуй нэмэгджээ.

Өөрөөр хэлбэл, индексийн зөрүү өндөр байгаа нь тус улсуудад банкны нөхцөл байдал, макро эдийн засаг, улс төрийн орчин хоорондоо өндөр ялгаатай байгааг илтгэж буй.

Ялангуяа сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ эрчимтэй нэмэгдэхийн хэрээр тухайн бүс нутгийн банкны салбарын ашигт ажиллагаа болон хүртээмж нэмэгдэж буй нь харагдаж байна. Гэвч нөгөө талаас геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэйгээр зарим бүс нутагт тодорхой бүс байдал, улс төрийн тогтворгүй байдал үргэлжилж байгаа нь тухайн улсын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж буйг харж болохоор байна.

Бүс нутгаарх банкны өрсөлдөх чадварын индексийн дундаж, голч өсжээ. Бүс нутгийн дунджийг 2020 оны байдлаар харвал, Хойд болон Өмнөд Америк, Европ болон Австралийн бүс нутаг дахь банкны өрсөлдөх чадварын индекс нь хамгийн өндөр байжээ. 2024 онд Хойд болон Өмнөд Америк болон Ойрх Дорнодын бүс нутгийн орнуудын дундаж нэмэгдэн хамгийн өндөр болж иржээ. Харин индексийн дунджаар хамгийн бага нь Төв ба Өмнөд Азийн бүс нутгийн орнууд хэвээр байна.

Банкны өрсөлдөх чадварын индекс



5. УЛС ОРНУУДЫН ОРЛОГЫН ТҮВШНЭЭРХ ШИНЖИЛГЭЭ

Банкны өрсөлдөх чадварын индексийн зөрүү орлого буурах тусам нэмэгдэж байсан бол сүүлийн жилүүдэд технологийн нөлөөгөөр банкны хүртээмжийн үзүүлэлт орлого багатай улсуудад улам сайжирч түүний нөлөөгөөр орлоготой багатай улсуудын индексийн зөрүү багассан байна. Мөн орлоготой багатай улсуудын хувьд хүний хөгжлийн үзүүлэлтүүд, технологийн үзүүлэлтүүд сайжрах нь индексийн утгад эергээр нөлөөлж буй нь ажиглагдлаа.

Дундаас доогуур орлоготой болон дунджаас дээгүүр орлоготой орнуудын хувьд индексийн зөрүү нэлээд өндөр хэвээр байна. Макро эдийн засгийн орчин болон банкны тогтвортой байдал нь эдгээр орлогын бүлэгт буй улс орнуудын хувьд харьцангуй тогтвортой биш байгааг илтгэж байна.


Орлогын түвшин дээшлэх тусам индексийн зөрүү багасахаас гадна индексийн ерөнхий оноо нэмэгджээ. Энэ нь дунджаас дээгүүр орлоготой

орнуудын макро эдийн засгийн орчин, улс төрийн орчин харьцангуй тогтворжиж эхэлдгээс гадна банкны салбарын хүртээмж, түүний гүнзгийрлийн үзүүлэлтүүд сайн, өрсөлдөх чадвар жил ирэх тутам нэмэгдэж буйтай холбоотой.

Түүнчлэн банкны өрсөлдөх чадварын индексээс макро орчны нөлөөллийг хасаж тооцоход бага болон дунджаас доогуур орлоготой орнууд дахь индексийн зөрүү улам нэмэгдэж байсан бол өндөр орлоготой улсуудын индексийн зөрүү хадгалагдаж байв. Энэ нь дунджаас доогуур орлоготой орнуудын орнуудын макро эдийн засгийн байдал тогтворгүй, улс төрийн орчин тодорхой бус байдалтай байгааг давхар илтгэж байна.

Монгол улсын хувьд орлогын ангилал ижил түвшинд буй орнуудын хувьд /дунджаас дээгүүр орлоготой бүлэг/ хамгийн сүүлийн байр эзэлж байсан бол 2025 оны өрсөлдөх чадварын судалгаагаар 4-р байранд орж иржээ.

Банкны өрсөлдөх чадварын индекс



6. МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ХААНА ЯВНА ВЭ?

Банкны өрсөлдөх чадварын индексээр 2020 онд Монгол Улс 37 улсаас 28-р байранд бичигдэж байсан бол 2024 онд 9-р байранд орсон байна. Түүнчлэн бүс нутаг, уул уурхайн хамаарал бүхий орон, орлогын ижил түвшний орнуудтай харьцуулан авч үзэхэд манай улсын өрсөлдөх чадвар харьцангуй сайжирсан болох нь харагдаж байна.


Харин дараагийн харах ёстой зүйл бол манай улсын макро орчны тогтворгүй байдал нь банкны өрсөлдөх чадварыг хойш татаж байсан уу? гэх асуудал.

Манай улсын хувьд цар тахлын эхэн үед эдийн засаг уналттай байсан бол 2021 оноос эхлэн эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд дүнтэй байсан.

2022 оноос эхлэн эдийн засгийн салбарууд аажмаар сэргэж сүүлийн 3 жил дараалан өсөлттэй, нөгөө талаас нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин аажмаар буурч эхэлсэн нь инфляц буурах боломжийг буй болгосон. Дээр нь эдийн засаг аажмаар сэргэж эхлэхтэй зэрэгцэн гадаад өрийн менежментийг хэрэгжүүлж эхэлсэн нь үр дүнтэй байжээ.

Макро орчны хүчин зүйлийг хасаж тооцсон (инфляц, гадаад өр) индексээр Монгол Улс нь 2020 онд нь 13 байр урагшилж 15-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 9 байрнаас урагшилж 6 байранд жагсжээ. Үүнээс харахад манай улсын хувьд макро эдийн засаг тогтвортой байх нь банкны салбарын өрсөлдөх чадварт эергээр нөлөөлдөг бөгөөд цаашид өрсөлдөх чадварыг хэвээр хадгалахын тулд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

Банкны өрсөлдөх чадварын индекс /Монгол Улсын эзэлсэн байр/



БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙГ ХЭРХЭН УНШИХ ВЭ?

1

Товч тайлбар хэсгээс тухайн индекс үзүүлэлтийг яагаад сонгосон, Монгол Улс хэддүгээр байр эзэлсэн зэрэг тайлбар мэдээллүүд байна.

2

Банкны өрсөлдөх чадварын индекс болон нэгдсэн дэд индексийг жагсаан үзүүлсэн. Мөн 2020 онд авсан оноо болон 2024 онд авсан оноог хооронд нь харьцуулан харах боломжтой.

3

Тус индекст тооцсон нэгж үзүүлэлтээр Монгол Улс хэддүгээр байран орж байгааг харуулсан. Түүнчлэн тухайн үзүүлэлтээр хамгийн сайн оноо авсан улсуудыг харж болно.


МОНГОЛ УЛС
7/37

1

Банкны үр ашигт байдлын индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 35-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 7-д жагсжээ.

БАНКНЫ ҮР АШИГТ БАЙДЛЫН ИНДЕКС

Манай улсын банкны салбарын активын болон өөрийн хөрөнгийн өгөөж бусад улстай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь банкны үр ашигт байдалд эерэгээр нөлөөлсөн.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Хүүгийн зөрүү	19	Сенегал
Активын өгөөж	9	Киргизстан
Өөрийн хөрөнгийн өгөөж	5	Мадагаскар

Банкны өрсөлдөх чадварын индекс 2024

7.БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН БҮРЭЛДЭХҮҮН




Банкны өрсөлдөх чадварын ерөнхий индексээр Монгол Улс 2024 онд 9-р байранд жагсжээ.

Байгалийн баялгаас хамааралтай Чили, Саудын Араб, Канад, Австрали болон Катар зэрэг хөгжингүй орнууд тэргүүн байрыг эзэлж байна.

Түүнчлэн Өмнөд Америкийн хөгжиж буй орнууд болох Бразил, Доминикийн Бүгд Найрамдах Улс гэх үйлчилгээний салбар түлхүү хөгжсөн улсууд индексийн эхний байруудыг эзэлж байна.

БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС



Хөгжиж буй болон уул уурхайгаас хэт хамааралтай улсуудын хувьд макро эдийн засгийн тогтвортой байдал нь тухайн улсын банкны салбарт ихээхэн нөлөөлж байдаг.

Тиймээс индексээс макро эрсдэлийн үзүүлэлтийг ялган авч үзсэн. Үр дүнд нь макро орчныг ялгасан

индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 28-р байранд эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 6 байранд жагсжээ. Эндээс харахад манай улс макро эдийн засгийн орчныг тогтвортой байлгахад ихээхэн анхаарал хандуулж чадвал банкны салбарын өрсөлдөх чадвар улам нэмэгдэх боломжтойг илтгэж байна.



Монгол Улс бүс нутгийнхаа түвшинд түүвэрлэгдсэн 5 орноос 2020 онд 4 дүгээр байранд эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 1 дүгээр байранд эрэмбэлэгджээ.

Сүүлийн 4 жилийн хугацаанд манай улсын банкны салбарт томоохон хууль, эрх зүйн өөрчлөлт хийгдэхээс гадна хүртээмжийн үзүүлэлт бусад улсуудтай харьцуулахад ихээхэн өндөр байгаа зэрэг нь эергээр нөлөөлж байна.

Дээр нь 2024 онд банкнуудын ашигт ажиллагаа сайжирсан, чанаргүй зээлийн хэмжээ буурч сүүлийн 15 жилийн доод хэмжээнд хүрсэн зэрэг нь индексийн утгад эергээр нөлөөлжээ.

Инфляц 2022 оны сүүлээс аажмаар буурч 2024 онд харьцангуй тогтворжсон, эдийн засаг сүүлийн 3 жил дараалан өсөлттэй байгаа зэрэг нь эергээр нөлөөлжээ.

Ерөнхий индексийн медианаараа Европ болон Австрали, Хойд болон Өмнөд Америкийн орнууд хамгийн өндөр оноотой байна.

Харин Сахарын Өмнөд Африк, Төв ба Өмнөд Азийн улсууд хамгийн бага медиантай байгаа нь банкны өрсөлдөх чадварын ялгаа нь улс орны тогтвортой байдал, геополитикийн хүчин зүйлсийн нөлөө их байгааг харуулж байна.

ЗҮҮН АЗИ БА НОМХОН ДАЛАЙ				ТӨВ БА ӨМНӨД АЗИ				САХАРЫН ӨМНӨД АФРИК			
БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025	БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025	БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025
9	Монгол	43.0	66.3	11	Казахстан	50.9	64.2	16	Намиби	58.9	58.9
12	Индонез	64.1	64.1	19	Тажикстан	57.4	57.4	18	Зимбабве	57.9	57.9
24	Филиппин	42.5	46.0	21	Узбекистан	56.2	55.5	20	Ботсвана	64.8	57.3
27	Хятад	52.9	44.8	23	Киргиз Улс	38.7	51.6	29	Өмнөд Африк	59.4	43.9
28	Вьетнам	49.7	44.2	30	Энэтхэг	41	42.5	31	Гана	47.7	39.7
				38	Пакистан	23.2	24.2	33	Мадагаскар	50.4	38.2
								34	Конго, Дем	36.4	36.4
								35	Камерун	30.2	34.4
								37	Сенегал	31.9	27.7
МЕДИАН ОНОО		46.0		МЕДИАН ОНОО		46.0		МЕДИАН ОНОО		44.0	

ЕВРОП БОЛОН АВСТРАЛИ				ХОЙД БОЛОН ӨМНӨД АМЕРИК				ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИК			
БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025	БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025	БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025
3	Австрали	65.5	70.8	1	Чили	61.0	79.0	2	Саудын Араб	73.3	73.3
14	Унгар	62.9	62.9	4	Канад	63.1	70.7	6	АНЭУ	67.6	67.6
				5	Бразил	76.5	68.3	7	Катар	67.4	67.4
				8	ДБНУ	66.6	66.6	13	Армен	57.1	63.7
				10	Мексик	70.8	65.6	17	Турк	61.1	58.1
				15	Перу	66.9	61.4	32	Марокко	40.5	38.7
				22	Колумб	65.1	55.1	36	Судан	34.8	32.3
				25	Боливи	49.8	45.0				
МЕДИАН ОНОО		66.8		МЕДИАН ОНОО		66.1		МЕДИАН ОНОО		63.6	

0-25 26-50 51-75 76-100

БҮС НУТГИЙН ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАХАД ГАДААД ӨРИЙН ДАРАМТ ӨНДӨР ХЭВЭЭР БАЙНА.

Зүүн Ази, Номхон Далайн орнуудтай харьцуулан эдийн засаг, хүний хөгжлийн голлох үзүүлэлтийг авч үзэв.

Монгол Улс бүс нутгийн орнуудтай харьцуулахад, хүний хөгжлийн индексээр сайн байгаа хэдий ч эдийн засгийн хэмжээгээрээ бага, инфляцын түвшин өндөр, гадаад өрийн дарамт ихтэй байгаа бол ажилгүйдэл өндөр хэдий ч бусад оронтой харьцуулахад харьцангуй хэвийн түвшинд байна. Дээр нь тухайн улсуудтай харьцуулахад экспортоос илүүтэйгээр импортод суурилсан эдийн засагтай, төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь харьцангуй өндөр ажээ.

Манай улсын эдийн засаг сүүлийн 3 жилийн хугацаанд тогтмол өссөн нь нэг хүнд оногдох орлогын хэмжээг нэмэгдүүлсэн бөгөөд 2024 онд Дэлхийн банкны ангиллаар дахин дундаас дээгүүр орлоготой орны тоонд багтсан.

Бүс нутгийн улсуудын хувьд 2010 оноос хойш нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт үргэлжилж байгаа ба цар тахлын эхэн үед Филиппин, Вьетнам улсаас бусад улсад тухайн үзүүлэлт уналттай байжээ.

Цар тахлын дараагийн жилээс буюу 2021 оноос эхлэн эдийн засгийн сэргэлт, идэвхжил нэмэгдсэнээр бүс нутгийн улсуудын нэг хүнд оногдох ДНБ нэмэгджээ.


Улс орнуудын хөгжлийн голлох үзүүлэлтүүд

/2024 оны байдлаар/

ҮЗҮҮЛЭЛТ	ФИЛЛИПИН	ВЬЕТНАМ	МОНГОЛ	ИНДОНЕЗ	ХЯТАД
Хүн ам, сая	115.8	101.6	3.5	277.7	1,430.8
Дундаж наслалт	72	75	71	73	78
Хүний хөгжлийн индексийн ранк	116	115	92	114	79
Хүний хөгжлийн индекс	0.70	0.70	0.74	0.71	0.76
Ажилгүйдэл	3.1	2.2	5.3	5.5	5
ДНБ, тэрбум \$	461.6	457.7	23.6	1,396.3	18,748.0
1 хүнд оногдох ДНБ, \$	4079.0	4,535.8	6,653	4,958.4	13,312
Инфляц	2.1	3.1	8	3.5	1.8
Урсгал тэнцэл/ДНБ	-3.8	6.6	-6.9	-0.6	2.2
Засгийн газрын өр/ДНБ	60.2	37.4	44.4	40	70

Эх сурвалж: Дэлхийн банк, Олон улсын валютын сан.

Нэг хүнд ногдох ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: Дэлхийн банк

Түүвэр сонгогдсон улс орнуудын индексийг орлогын түвшнээр нь авч үзье.

Монгол Улс 2020 онд дунджаас дээгүүр түвшинд түүвэрлэгдсэн 15 орноос 15-р байранд жагсаж байсан бол 2024 онд 3-р байранд жагссан байна. Макро эдийн засгийн хүчин зүйлсийг хасаж тооцвол 2-р байранд эрэмбэлэгджээ. Манай улсын макро эдийн засгийн орчин болон улс төрийн нөхцөл байдал сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байсан нь индексийн утгад эергээр нөлөөлсөн. Мөн ижил орлоготой улсуудтай харьцуулахад санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд харьцангуй дээгүүр түвшинд байна.

Өндөр орлоготой орнууд хамгийн өндөр оноотой байгаа ба бага орлоготой улсууд хамгийн бага медиантай байна. Орлогын ялгаанаас үүдэлтэйгээр индексийн онооны зөрүү ялгаатай байгаа нь харагдаж байна.

Уул уурхай, Металлын Олон Улсын Зөвлөл (ICMM) нь эдийн засаг нь уул уурхайн орлогоос онцгой хамааралтай улс орны жагсаалтыг ДНБ-д эзлэх уул уурхайн үйлдвэрлэл, экспортод эзлэх хувь, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтөөр тооцон гаргадаг. Иймд ижил орлоготой уул уурхайн бүтээгдэхүүнээс хамаарал өндөртэй улсуудтай индексийн утгыг харьцуулах нь чухал ач холбогдолтой байдаг.

ДУНДЖААС ДООГУУР ОРЛОГОТой ОРНУУД				ДУНДЖААС ДЭЭГҮҮР ОРЛОГОТой ОРНУУД			
БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025	БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025
18	Зимбабве	57.9	57.9	5	Бразил	76.5	68.3
21	Узбекистан	56.2	55.5	8	ДБНУ	76.5	66.6
23	Киргизстан	38.7	51.6	9	Монгол	43.0	66.3
24	Филиппин	42.5	46.0	10	Мексик	70.8	65.6
25	Боливи	49.8	45.0	11	Казахстан	50.9	64.2
28	Вьетнам	49.7	44.2	12	Индонез	64.1	64.1
30	Энэтхэг	41.0	42.5	13	Армен	57.1	63.7
31	Гана	47.7	39.7	15	Перу	66.9	61.4
32	Марокко	40.5	38.7	16	Намиби	58.9	58.9
35	Камерун	30.2	34.4	17	Турк	61.1	58.1
37	Сенегал	31.9	27.7	20	Ботсвана	64.8	57.3
38	Пакистан	23.2	24.2	22	Колумб	65.1	55.1
				27	Хятад	52.9	44.8
				29	Өмнөд Африк	59.4	43.9
МЕДИАН ОНОО			43.2	МЕДИАН ОНОО			62.5

ӨНДӨР ОРЛОГОТой ОРНУУД				БАГА ОРЛОГОТой ОРНУУД			
БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025	БАЙР	УЛС	ОНОО 2020	ОНОО 2025
1	Чили	61.8	79.0	33	Мадагаскар	50.4	38.2
2	Саудын Араб	73.3	73.3	34	Конго, Дем	36.4	36.4
3	Австрали	65.5	70.8	36	Судан	34.8	32.3
4	Канад	63.1	70.7				
6	АНЭУ.	67.6	67.6				
7	Катар	67.4	67.4				
14	Унгар	62.9	62.9				
МЕДИАН ОНОО			70.7	МЕДИАН ОНОО			36.4

0-25 26-50 51-75 76-100


УУЛ УУРХАЙН ХАМААРЛААС ГАРНА ГЭДЭГ ИХЭЭХЭН
СОРИЛТ ДАГУУЛДАГ, АМАРГҮЙ ЗҮЙЛСИЙН НЭГ.

Уул уурхайн хамааралтай 21 улсыг индексийн тооцоололд хамруулсан бөгөөд 2020 онд 13-т жагсаж байсан бол 2024 онд 3-т эрэмбэлэгджээ.

Дэлхийн банкны ангиллаар дунджаас дээгүүр орлоготой уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай орнуудын эдийн засаг, хүний хөгжлийн голлох үзүүлэлтийг авч үзэв. /Доорх хүснэгтэд/

Монгол Улс нь тус улсуудаас инфляц өндөр, урсгал тэнцлийн алдагдал өндөр, гадаад өрийн дарамттай, газарзүйн байршил сул талтай байна. Эдийн засгийн өсөлт өндөр ч савлагаа ихтэй, тогтворгүй байна. Байгалийн баялгаас хамаарал бүхий улсууд нь эдийн засаг дах уул уурхайн нөлөөг багасгах зорилгоор 1960 оноос хойш төрөл бүрийн бодлого, хөтөлбөр явуулж ирсэн ч өнөөг хүртэл тодорхой амжилтад хүрээгүй байна.

УУЛ УУРХАЙН ХАМААРАЛ БҮХИЙ ОРНУУДААРХ АНГИЛАЛ




Улс орнуудын хөгжлийн голлох үзүүлэлтүүд /2024 оны байдлаар/

ҮЗҮҮЛЭЛТ	КАЗАХСТАН	БОТСВАНА	МОНГОЛ	ПЕРУ	КОЛУМБ
Хүн ам, сая	19.9	2.5	3.5	34.5	52.2
Дундаж наслалт	73	59	71	77	77
Хүний хөгжлийн индексийн ранк	56	100	92	84	88
Хүний хөгжлийн индекс	0.81	0.735	0.737	0.76	0.75
Ажилгүйдэл	4.6	27.6	5.3	6.4	8.2
ДНБ, тэрбум \$	261.4	19.4	23.6	267.6	363.5
1 хүнд оногдох ДНБ, \$	11,453	7,341	6,653	6,455	6,850
Инфляц	8.6	2.8	8	2.0	5.2
Урсгал тэнцэл/ДНБ	-3.3	0.9	-6.9	0.6	-2.7
Засгийн газрын өр/ДНБ	24.4	23.3	44.4	32.7	61.8

Эх сурвалж: Дэлхийн банк, Олон улсын валютын сан.

Банкны үр ашигт байдлын индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 35-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 7-д жагсжээ.


Манай улсын банкны салбарын активын болон өөрийн хөрөнгийн өгөөж бусад улстай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь банкны үр ашигт байдалд эергээр нөлөөлсөн.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР		ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС	
Хүүгийн зөрүү	19	Сенегал	
Активын өгөөж	9	Киргизстан	
Өөрийн хөрөнгийн өгөөж	5	Мадагаскар	

Банкны эрсдэлийн индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 26-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 20-д жагсжээ.


Сүүлийн жилүүдэд зээл олголт нэмэгдсэнтэй холбоотой банкны чанаргүй зээлийн хэмжээ буурсан нь индексийн утгад эергээр нөлөөлжээ.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР		ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Хөрвөх чадварын үзүүлэлт	22	Пакистан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	2	Киргизстан
Чанаргүй зээлийн хэмжээ	17	Канад

Банкны үр ашигт байдлын индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 12-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 20-д жагсжээ.


Сүүлийн жилүүдэд банкны салбар нь иргэд чиглэсэн зээлийг түлхүү олгож хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ буурсан нь нөлөөлжээ.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Хувийн секторын зээлийн ДНБ-д эзлэх хувь	16Канад

Банкны эрсдэлийн индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 2-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд байраа хадгалж үлдсэн байна.

Манай улсын банканд данстай иргэдийн тоо, нэг хүнд оногдох АТМ болон банкны салбарын тоогоор дэлхийд дээгүүр хэвээр байна.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
100,000 хүнд оногдох банкны салбарын тоо	2	Боливи
100,000 хүн оногдох АТМ-ийн тоо	13	Канад

БАНКНЫ САЛБАРЫН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАРЬЦАНГУЙ САЙН БАЙНА.

МУ-ын насанд хүрсэн хүн амын 98% нь банканд данстайгаас гадна нийт төлбөр тооцооны 97% нь дижитал хэлбэрээр явагдаж байгаа нь бүс нутагтаа санхүүгийн зах зээлийн дижиталжилт эрчимтэй явагдаж буй орны тоонд багтах аас гадна санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүдээр өндөр хөгжилтэй улсуудтай ижил түвшинд байна.

Интернэт банк хэрэглэгчийн тоо 2020 онтой харьцуулахад 2 дахин, мобайл банк хэрэглэгчдийн тоо 7 дахин өсжээ. Үүнийг дагаад хэрэглэгчид мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг гар утас, ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан авах сонирхолтой болжээ.

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ

Банканд данстай иргэдийн төгрөгийн хуримтлал бий болгох хандлагыг нэмэгдүүлэх, түүнийг иргэдэд төлөвшүүлэх нь чухал байна. Манай улсын иргэдийн хадгалах хандлага бусад улсуудтай харьцуулахад бага түвшинд байна.

Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдээллийн технологийн дэвшлийг ашигласан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх, одоогийн үйлчилгээг боловсронгуй болгох шаардлагатай тулгарч байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд иргэдэд олгосон зээлийн хэмжээ дунджаар 20%-ийн өсөлттэй байгаа хэдий ч банкнаас шинээр зээл авч буй хэрэглэгчдийн тооны өсөлт харьцангуй бага түвшинд байна.

Уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралт, дунджаас дээгүүр орнуудтай харьцуулахад манай улсын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгож буй зээлийн хэмжээ харьцангуй бага байна.

Иймд цаашид уул уурхайн хамаарлаас гарах, санхүүгийн хүртээмжийн гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

Мөн интернэт ашиглах боломжгүй иргэдэд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг ойртуулах, интернэт банк тогтмол хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах замаар банкны салбарын хүртээмжийн гүнзгийрлийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Эцэст нь санхүүгийн хэрэглэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, ухаалаг байдлаар банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

БАНКНЫ ХҮРТЭЭМЖИЙН ГҮНЗГИЙРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА ӨНДӨР БАЙНА.



15%

банкаар тогтмол үйлчлүүлдэггүй



29%

зайнаас үйлчилгээ авдаггүй



17%

интернэт ашиглах боломжгүй




10 хүн тутмын 9

нь яаралтай санхүүгийн хэрэгцээ гарвал найз, нөхөд гэр бүлдээ ханддаг



53%

ямар нэг зээлтэй. 34% нь санхүүгийн байгууллагаас



72%

хадгаламжгүй


Эх сурвалж: Global Findex Database—2021

⁴ Үндэсний статистикийн хороо

⁵ Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2024 оны жилийн эцсийн тайлан

Банкны үр ашигт байдлын индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 35-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 21-д жагсжээ.

2022 оны сүүлээс инфляцын түвшин аажмаар буурч 2024 онд нэг оронтой тоонд хадгалагдсан нь макро эрсдэлийн индекс нэмэгдэхэд нөлөөлжээ.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Инфляцын түвшин	20	Хятад
Улсын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь	17	Ботсвана

ИРЭХ ЖИЛҮҮДЭД ГАДААДЫН ӨРИЙН ДАРАМТ ХАРЬЦАНГУЙ БАГА БАЙНА.

Монгол Улсын нийт гадаад өр 2019 онд ДНБ-ны 63 хувийг эзэлж байсан бол 2024 онд 41 хувийг эзэлж байна. Энэ хугацаанд засгийн газрын зүгээс бондын эргэн төлөлтийг хойшлуулах, бонд шинээр босгох зэрэг өрийн удирдлагын арга хэмжээг оновчтой хэрэгжүүлсэн, дээр нь тодорхой хэмжээнд гадаад өрийн төлөлтийг тогтмол хийж ирсэн нь богино хугацааны өрийн дарамтаас гарахад чухал нөлөө үзүүлсэн байна.

Дээр нь сүүлийн 2 жилийн хугацаанд экспортын орлого тогтмол нэмэгдсэн, гадаад өр шинээр тавиагүй зэрэг нь гадаад өрийн хэмжээ буурахад чухал нөлөө үзүүлсэн. Ирэх онуудад гадаад өрийн дарамт харьцангуй бага байна.

Улсын нийт гадаад өр 2024 онд 37.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 2.5 (7.4%) тэрбум ам.доллараар, өмнөх улирлаас 1.5 (4.1%) тэрбум ам.доллараар тус тус өссөн байна. Улсын нийт гадаад өр 2024 онд өмнөх оноос өсөхөд шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг өссөн нь нөлөөлсөн. Мөн валютын ханшийн өөрчлөлтөөс үүдэлтэй гадаад өрийн хэмжээ тодорхой хэмжээнд өсөлт үзүүлжээ.

Экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнийн болон тоо хэмжээний бууралттай холбоотой төсвийн орлого бүрэлдэхгүй байх, төсвийн орлого тасарвал төсвийн алдагдлыг өрөөр санхүүжүүлэх, өрийн дарамтад эргээд орох эрсдэл өндөр байна.

Эргэн төлөлт/тэрбум төгрөг/


Эргэн төлөлт	2020	2021	2022	2023	2024	Нийт дүн
Үндсэн төлбөр	2,506	1,327	1,419	5,119	2,280	12,652
Хүүгийн төлбөр	881	958	757	1,080	1,125	4,801

Номад бонд
600 сая доллар

Сэнчүри 1,2
1,000 сая доллар

Сэнчүри 3
650 сая доллар


Засгийн газрын гадаад өр/ДНБ/



Эх сурвалж: Үндэсний статисткийн хороо

Банкны эрсдэлийн индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 18-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 10-д жагсжээ. Тухайн орны хүн амын

хөгжлийн индекс нь дундаж наслалт, боловсролын түвшин болон амьжиргааны түвшинг багтаан тооцдог.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР		ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС	
1 хүнд ногдох ДНБ	11	Катар	
Хүний хөгжлийн индекс	11	Австрали	

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСЭЭР ДЭЛХИЙН ДУНДЖААС ДЭЭГҮҮР ТҮВШИН БАЙНА.

Дэлхий нийтээрээ хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас гадна хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулах болсон. Улс үндэстний гол баялаг, хөгжлийн хүч, ирээдүйг тодорхойлогч үнэт зүйл бол хүн гэж тодорхойлжээ. Хүний хөгжил гэдэг бол товчхондоо хүн төвтэй хөгжил - үйл явц хийгээд үр дүн юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийг хөгжүүлэх, хөгжлийг хүмүүст зориулах, хүмүүсийн өөрсдийнх нь оролцоотойгоор хөгжлийг хангана гэсэн үг.

Хөгжлийн үндсэн зорилго нь хүнийг эрүүл саруул байх, урт удаан наслах, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг хүмүүст бүрдүүлэхэд чиглэж байна.

Манай улсын хувьд хүний хөгжлийн индексээр дэлхийн дундажтай харьцуулахад дээгүүр байгаа юм. Манай улсын хүн амын дундаж наслалт 2015-2020 онд 0.82 жилээр, сургуульд суралцах хугацаа 0.02 жилээр, сургуульд суралцахаар хүлээгдэж буй хугацаа 0.2 жилээр, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 10.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүний хөгжлийн индексийн үндсэн үзүүлэлтийн нэг болох хүн амын дундаж наслалт жил бүр нэмэгдэж байгаа боловч эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү хэвээр хадгалагдсаар байна.


Нийт хүн амын 50.7 хувийг эзлэх эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.2 жил байгаа бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.7 жил байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 9.5 жилээр доогуур байна. Энэ нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд анхаарах цаг болсныг сануулж байна.

Монгол Улсын хувьд боловсролын салбарт нэлээдгүй өөрчлөлт гарч буй боловч хүн амын нягтралаас шалтгаалж Улаанбаатар хотод дийлэнх их, дээд сургууль, дунд сургууль, цэцэрлэг байршиж байгаагаас Улаанбаатар хотын боловсролын индекс бусад аймгуудаас өндөр байсаар байна.

Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа боловч ажиллах хүчний оролцооны түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 15.0 нэгж хувиар доогуур байдаг. Энэ нь эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд болон цалин хөлс, орлогын хувьд жендерийн ялгаатай байдлыг харуулж байна.

Мөн шийдвэр гаргах эрх мэдлийн түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байна. Энэ нь улс төр болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих хэрэгтэйг харуулж байна.


Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексүүд /2023 он/



Эх сурвалж: Үндэсний статисткийн хороо

Банкны үр ашигт байдлын индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 24-д эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 21-д жагсжээ.

Сүүлийн 8 жилийн хугацаанд улс төр харьцангуй тогтвортой байна. Тийм боловч бизнесийн таатай орчин бүрдээгүй, авлига өндөр хэвээр байна.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР		ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС	
Бизнесийн таатай орчны индекс	15	Арабын нэгдсэн Эмират Улс	
Авилгалын индекс	16	Австрали	
Улс төрийн тогтвортой байдлын индекс	10	Австрали	

УЛС ТӨРИЙН ОРЧИН ТОГТВОРТОЙ БАЙГАА Ч АВИЛГАЛ, БИЗНЕС ХИЙХ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ ДОРВИТОЙ САЙЖРАХГҮЙ БАЙНА.

Авлигын индексээр дэлхийн 180 улсаас Монгол улс 2024 онд 114-р байранд жагсаж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 7 байраар урагшилсан. Манай улсын авилгалын индексийн оноо 2022 оноос эрчимтэй буурч, авилгал нэмэгдэж буй 10 улсын нэг болсон. Тухайлбал, 2023 онд ардчиллын индекс болон авлигын индексээр Монгол Улс саарал бүсэд орсон бөгөөд энэ жил ч мөн адил түвшинд байна. Өөрөөр хэлбэл энэ нь ардчилал алдагдахаас гадна, хууль засаглалын хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэдэг.

Нийт 8 эх сурвалжаар үнэлэгдсэн үзүүлэлтүүдийн 3 нь бага зэрэг өссөн, харин 5 нь буурсан байна. Эдгээр 8 эх сурвалжийн 3 нь эрсдэлтэй гэсэн үнэлгээтэй. Эдийн засаг, уул уурхай, санхүүжилтийн олдоц зэрэг үзүүлэлтүүд дээр тодорхой ахиц гарсангүй. Бизнес эрхлэгчдийн үнэлгээнд тодорхой ахиц гараагүй бөгөөд энэ нь бизнес эрхлэх дэд бүтэц хөгжөөгүй, санхүүгийн эх үүсвэрүүдийн зээлийн хүү өндөр байгаа зэрэг шалтгаантай байна.

Ардчиллын үзүүлэлтээр бид маш өндөр уналт үзүүлсэн бөгөөд хүний эрхийн хэрэгжилт, хүний эрхийн сургалт, хууль сахиулах байгууллагын хүний эрхийн мэдрэмжийг дээшлүүлэх чиглэлд огт өөрчлөлт гараагүй гэдгийг Авлигын индексийн тайланд онцолсон байна.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй (Doing Business)-2020” судалгаагаар бизнес эрхлэхэд амар хялбар байдлаар Монгол Улс дэлхийн 190 орноос 81-т жагсаж байна. Энэ нь бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад дээгүүр байр боловч цаашид бизнесийн орчинг сайжруулах шаардлага өндөр хэвээр байгаа юм.


Монгол Улсын хувьд хуулийн этгээдийг бүртгүүлэх, банкны үйлчилгээ авах, үйл ажиллагаа явуулах газрыг сонгох зэрэг үзүүлэлтээр бусад улсуудтай харьцуулахад сайн байна.

Харин эрчим хүчний тасралтгүй байдал, гадаад худалдаа эрхлэх, бизнесийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг үзүүлэлтээр бусад улсуудтай харьцуулахад харьцангуй сул байна.

Хамгийн чухал асуудал нь өр төлбөрийг барагдуулах, өр төлбөр төлүүлэхэд гарч буй хүндрэл нь ихээхэн цаг хугацаа алддаг тул бизнес хийхэд тохиромжгүй гэдэг үзүүлэлтээр бусад улсуудтай харьцуулахад сүүл мушгисан байна.

Тиймээс төлбөрийн чадваргүйдэл, зээлийн эргэн төлөлттэй холбоотой хууль, эрх зүйн шинэчлэлтийг хийх нь банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээс гадна, гадаадын хөрөнгө оруулалтыг татах томоохон хөшүүрэг болох нь харагдаж байна.


Авлигын индекс



Эх сурвалж: Transparency international

Банкны эрсдэлийн индексээр Монгол Улс 2020 онд 37 улсаас 23-д байсан бол 2024 онд 3-д эрэмбэлэгджээ. Тус үзүүлэлтийг хүн амын дунд гар утас болон интернэт хэрэглэгчийн тоогоор

хэмжиж үзсэн. Хүн амын гар утас болон интернэт хэрэглээ нь банкны салбарын дижитал үйлчилгээг цаг хугацаа, орон зай харгалзахгүй ашиглах боломжийг бүрдүүлдэг.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР		ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Нийт хүн амд эзлэх гар утас эзэмшигчдийн тоо		Арабын Нэгдсэн Эмират Улс
Нийт хүн амд эзлэх интернэт хэрэглэгчдийн тоо		Австрали

ИНТЕРНЭТ БАНК ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО УЛАМ БҮР НЭМЭГДСЭЭР....

Мэдээлэл технологийн хөгжил жил бүр нэмэгдэхийн хэрээр интернэт хэрэглэгчийн тоо улам бүр нэмэгдсээр байна. Тухайлбал, Монгол улсын интернэт хэрэглэгчийн тоо 2020 онтой харьцуулахад 2024 онд 25 хувиар нэмэгдэж 4.8 саяд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл нийт хүн амын тооноос олон хүмүүс интернэтийг ашиглаж байгаа нь харагдаж байна.


Ийнхүү интернэт хэрэглэгчийн тоо нэмэгдэж, иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн хэрээр банкны үйлчилгээг зайнаас авах, хурдан шуурхай бөгөөд зардал багатай ашиглах хэрэглэгчийн тоо улам бүр нэмэгдсээр байна.

Тухайлбал, интернэт банк хэрэглэгчийн тоо 2020 оноос 89 хувиар нэмэгдэж 2024 онд 5 саяд хүрсэн бөгөөд эдгээр хэрэглэгчдээс 50 хувь нь идэвхтэй ашиглаж байна. Мобайл хандалт ашигладаг хэрэглэгчдийн хувьд 2020 онтой харьцуулахад 74 хувиар нэмэгдэж 2.4 саяд хүрчээ.

Интернэт банк идэвхтэй хэрэглэгчид 2020 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн бол мобайл банк хэрэглэгчийн хувьд 37 хувиар буурчээ.


Сүүлийн 4 жилд дунджаар 100,000 хүн шинээр интернэт банкны хэрэглэгчээр бүртгүүлдэг бол 35,327 хүн мобайл банкны хэрэглэгчээр бүртгүүлдэг байна.

Интернэт хэрэглэгчийн тоо




Эх сурвалж: Үндэсний статисткийн хороо

Цахим банкны хэрэглэгчийн тоо



Цахим банк идэвхтэй хэрэглэгчийн хувь



Эх сурвалж: Монголбанк

8.БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС ТООЦОХ АРГА, АРГАЧЛАЛ

АГРЕГАТ ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ:

Банкны өрсөлдөх чадварын индексийг олон хэмжээст өгөгдлийг хураангуй индекс болгох аргачлалыг ашиглан (i) хувьсагчдыг нормалчлах; (ii) нормалчлагдсан хувьсагчдыг дэд индексүүд рүү нэгтгэх; (iii) дэд индексүүдийг эцсийн индекс болгон нэгтгэх байдлаар тооцоолсон. Банкны өрсөлдөх чадварын индексэд харилцан адилгүй, өөр төрлийн хэмжээс болон бүтэц бүхий индикаторуудыг нэгтгэн тооцоолохын тулд индикатор тус бүрийг “0- 100”-ын хооронд оноолов. Индикатор тус бүрийг дараах томъёоны дагуу хувирган тооцоолов:

$$\text{Оноо}_{ic} = \underbrace{\left(\frac{\text{Бодит утга}_{ic} - \text{Мин утга}_i}{\text{Макс утга}_{ic} - \text{Мин утга}_i} \right)}_{\alpha} \times 100_i$$

Үүнд: Бодит утга нь “с” улсын “i” индикаторын цэвэр үзүүлэлт нь байх ба Мин утга нь тус үзүүлэлтийн хүлээн зөвшөөрөгдөх доод хэмжээг илэрхийлнэ. Мөн “Макс утга” нь тус үзүүлэлтийн байж болох дээд хэмжээг илэрхийлж буй болно. Индикатор тус бүрээс хамааран Макс утга нь тухайн үзүүлэлтийн бодлогын зорилтот дүн, боломжит дээд хэмжээ эсхүл перцентилд суурилсан дээд хэмжигдэхүүнийг илэрхийлнэ (жишээ нь дээд 90-95 дахь перцентилээс дээш гүйцэтгэл). Бодит утга нь “Мин утга” –аас бага байгаа тохиолдолд оноо нь 0 байх ба хэрвээ бодит утга нь Макс утгаас өндөр байвал оноо нь 100 байхаар тооцооллыг хийсэн. Хэрэв тухайн индикатор урвуу индикатор байх тохиолдолд (жишээ нь гадаад өрийн ДНБ-д эзлэх хэмжээ, Чанаргүй зээлийн хэмжээ г.м.) дээрх үзүүлэлтийг 100-с хасаж тооцох ба ингэснээр үзүүлэлтүүдийг нэгтгэх боломжтой болно.

ДУТУУ ТООН ӨГӨГДЛИЙН ТООЦООЛОЛ:

1. Дутуу тоон өгөгдлийн тооцоолол буюу “Missing data”-г нөхөхөд хугацаан цуваан тоон мэдээлэл дээр шугаман регрессийн шинжилгээ ашиглан тооцов. Тухайлбал АТМ-ны тоо хүртээмжийн үзүүлэлтийг тооцоход үл хамааран хувьсагчид Хүн амын тооны өсөлт, Нэг хүнд ноогдох ДНБ-ийг ашиглан тооцоолов.
2. Харин хугацаан цувааны регрессээр илэрхийлэхэд логикийн хувьд үл тайлбарлагдах үзүүлэлтүүдийг Бүс нутаг, эдийн засгийн ижил төсөөтэй орнуудын үзүүлэлтийг дундажлах аргаар (Peer mean) тооцсон болно. Тухайлбал: Хувийн секторт олгосон зээлийн хэмжээг ДНБ-д эзлэх хувийг бүс нутгийн харьяалал (ОУВС) болон орлогын түвшний ангиллын (Дэлхийн банк) хувьд ижил төсөөтэй орнуудын дунджаар илэрхийлэв.
3. Зарим улсуудын 2024 оны жилийн эцсээрх тоон мэдээлэл хараахан гараагүй, эсхүл олон улсын байгууллага болон тухайн улсын статистикийн байгууллагад байхгүй тохиолдолд өмнөх 5 жилийн дунджийг авч ашигласан.

Банкны салбарын өрсөлдөх чадварын индексийг боловсруулахдаа дараах процедурийн дагуу гүйцэтгэв. Тус индексийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) нийлмэл хувьсагч боловсруулах гарын авлагын онол практикийн зөвлөмжийн дагуу боловсруулсан болно.

1. ОНОЛЫН ХҮРЭЭ

- Банкны өрсөлдөөний хүчин зүйлсийн ойлголтыг нэгтгэх
- Өрсөлдөх чадварт нөлөөлөх, өрсөлдөх чадварыг илэрхийлэх дэд бүлгүүд боловсруулах

2. ТООН ӨГӨГДӨЛ СОНГОЛТ

Шинжилгээ хийхэд тохиромжтой эсэх, хэмжигдэхүйц байдал, улсууд даяарх бэлэн байдал, банкуудын өрсөлдөх чадварын хүчин зүйлийг илэрхийлэхэд тохиромжтой эсэх мөн хоорондын харилцан хамаарлуудыг ажиглаж үзүүлэлтүүдийг сонгох. Хувьсагчийн хүртээмж бага тохиолдолд прокси хувьсагч сонгох.

3. ДУТУУ ӨГӨГДЛИЙГ ТООЦООЛОХ

- Дутуу тоон өгөгдлийн тооцооллыг хийх
- Тооцооллын найдвартай байдлыг үнэлэх, тоон үзүүлэлт нөхснөөр нэгтгэсэн үзүүлэлтэд үзүүлэх нөлөө
- Тоон өгөгдөлд гажууд утга (outliers) байгаа эсэхийг тодорхойлох

4. ОЛОН ХУЬСАГЧДЫН ШИНЖИЛГЭЭ

2 голлох хэмжээст болох үзүүлэлт болон улсаар нь харьяалагдах тоон өгөгдлийн бүтцийг шалгах, тухайлбал (тохирох олон хувьсагчдын арга аргачлал, кластер шинжилгээ)

- Статистикийн хувьд ижил төстэй улсуудыг тодорхойлох, үр дүнг тайлбарлах
- Статистикийн хувьд ижил төстэй дата сетүүдийг онолын хувьд олж илрүүлэх.

5. ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ НОРМАЛЧЛАХ

- Онолын хүрээ болон тоон өгөгдлийн шинж чанарт тохирох нормалчлалын аргачлалыг сонгох
- Тоон өгөгдөлд гажууд үзүүлэлт байгаа эсэхийг тодорхойлж, хүсээгүй хандлагыг илэрхийлэхгүй байхаар тооцооллыг засварлах,
- Шаардлагатай тохиолдолд хамрах хүрээний хувьд засварлалт хийх
- Шаардлагатай тохиолдолд хэт налалттай үзүүлэлтийг засварлах

6. ЖИНЛЭХ, АГРЕГРАТЧИЛАХ

- Онолын хүрээ болон тоон өгөгдлийн шинж чанарт тохирох жинлэх, агрегатчилах аргачлалыг сонгох
- Үзүүлэлтүүдийн хооронд корреляц байгаа эсэхийг тодорхойлох, засварлах шаардлагатай эсэхийг тодорхойлох

- Үзүүлэлтүүдийг орлуулах боломжийг тодорхойлох

7. ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫГ ШИНЖЛЭХ

Индексд харгалзах бүхий л тодорхой бус байдлуудыг дурдах, үүнд харгалзах тодорхой бус байдлаар нь оноолох, зэрэглэл үүсгэх

8. ИНДЕКСИЙГ ШАЛГАХ

- Улс орны үзүүлэлтийг гаргаж харьцуулах, улмаар тухайн индексийн үр дүн нь ямар үзүүлэлтээр түлхүү илэрхийлэгдэж буйг тодорхойлох
- Хамаарал ба учир шалтгааныг тодорхойлох
- Хэт давамгайлж буй үзүүлэлтүүд байгаа эсэхийг тодорхойлж, засварлах, эсхүл тус үзүүлэлтийн ач холбогдлыг тайлбарлах

9. ХОЛБОГДОХ БУСАД ИНДЕКСҮҮДТЭЙ ХАМААРЛЫГ СУДЛАХ

- Боловсруулсан индексийн хамаарал бүхий бусад үзүүлэлтүүдтэй харьцуулах
- Үр дүнг тоон өгөгдөлд суурилсан өгүүлэмжээр илэрхийлэх

1-Р БҮЛЭГ:

Банкны үр ашигт байдлын индекс

1.1. Хүүний зөрүү

(Зээлийн хүү) – (хадгаламжийн хүү) = (Хүүний зөрүү)

Банкны системийн зээлийн жигнэсэн дундаж хүү болон эх үүсвэрийн жигнэсэн дундаж хүүний зөрүү нь банкнуудын ашигт ажиллагааг илэрхийлэх нэг үзүүлэлт юм.

1.2. Активын өгөөж

(Нийт орлого) / (Нийт Актив) = (Активын өгөөж)
Активын өгөөж нь цэвэр ашгийг нийт активт харьцуулсан харьцаа юм. Энэ нь нэгж активаас хэдэн хувийн өгөөж авч байгаа илэрхийлж байгаа ашгийн үзүүлэлт юм. Активын өгөөж нь нийт активаа хэр хэмжээний үр ашигтайгаар удирдаж байгааг харуулдаг голлох үзүүлэлт бөгөөд банкны системд өргөн ашиглагддаг үзүүлэлт юм.

1.3. Өөрийн хөрөнгийн өгөөж

$(\text{Нийт орлого}) / (\text{Нийт Өөрийн Хөрөнгө}) = (\text{Өөрийн хөрөнгийн өгөөж})$

Татварын дараах цэвэр ашгийг нийт өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцааг өөрийн хөрөнгийн өгөөж гэж нэрлэнэ. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн өгөөж жилд хэдэн хувиар өөрчлөгдсөнийг илэрхийлж буй үзүүлэлт юм.

2-Р БҮЛЭГ:

Банкны эрсдэлийн индекс

2.1. Хөрвөх чадвартай активын нийт активт эзлэх хувь

$(\text{Хөрвөх чадвартай активын нөөц}) / (\text{Нийт Актив})$

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь компанийн богино хугацааны үүрэг, мөнгөн гүйлгээг нөхөх чадварыг тодорхойлдог учраас банкны эрсдэлийг тодорхойлоход оновчтой үзүүлэлт юм.

2.2. Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ

$(\text{Нийт өөрийн хөрөнгө}) / (\text{Нийт Актив}) = (\text{Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ})$

Эрсдэлт үед банкны активыг санхүүжүүлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсхийг тооцоолдог тус үзүүлэлт нь улс хоорондын харьцуулалт гаргахад тохиромжтой үзүүлэлт юм.

2.3. Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ

$(\text{Нийт чанаргүй зээлийн хэмжээ}) / (\text{Нийт зээлийн хэмжээ}) * 100\% = (\text{Чанаргүй зээлийн харьцаа})$

Чанаргүй зээлийн харьцаа: Тус үзүүлэлт олон улсад банкны салбарын активын чанарыг харьцуулдаг цөөхөн үзүүлэлтүүдийн нэг билээ.

3-Р БҮЛЭГ:

Банкны гүнзгийрлийн индекс

3.1. Бизнесийн зээл болон ДНБ-ийн харьцаа

$(\text{Дотоодын бизнесийн зээлийн хэмжээ}) / (\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн}) = \text{Бизнесийн зээл болон ДНБ-ийн харьцаа}$

Хувийн секторын зээлийн ДНБ-д эзлэх хувь: Энэ нь банкны салбарын санхүүгийн зах зээл дэх гүнзгийрэлтийг харуулдаг. Өөрөөр хэлбэл, тухайн санхүүгийн зах зээлээс хувийн байгууллагад хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байгаагаас гүнзгийрэлт их, бага байгаа нь харагддаг.

Нийт хувийн байгууллагуудад олгосон зээлийн хэмжээг нийт дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулснаар бусад улс орнуудтай харьцуулах боломж бүрдэнэ.

4-Р БҮЛЭГ:

Банкны хүртээмжийн индекс

4.1. 100,000 хүнд ногдох банкны салбарын тоо

$(\text{Нийт банкны салбарын тоо}) / (\text{Нийт хүн амын тоо}) * 100,000 = 100,000 \text{ хүнд ногдох банкны салбарын тоо}$

100 мянган хүн ам тутамд эзлэх банкны салбарын тоо: Энэ нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ хүн амд хүртээмжтэйгээр хүрч чадаж байгаа эсхийг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг билээ.

4.2. 100,000 хүнд ногдох АТМ-ын тоо

$(\text{Нийт АТМ-ын тоо}) / (\text{Нийт хүн амын тоо}) * 100,000 = 100,000 \text{ хүнд ногдох АТМ-ны тоо}$

100 мянган хүн ам тутамд эзлэх АТМ төхөөрөмжийн тоо: Энэхүү үзүүлэлт нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ хэр хүртээмжтэй байгааг илэрхийлдэг учраас банкны өрсөлдөөнийг тодорхойлох чухал үзүүлэлт болдог.

5-Р БҮЛЭГ:

Макро эрсдэлийн индекс

5.1. Инфляц, хэрэглээний үнээр (жилээр)

$(\text{Өмнөх жилийн хэрэглээний үнийн индекс}) / (\text{тухайн жилийн хэрэглээний үнийн индекс}) * 100 - 100 = (\text{Инфляцийн түвшин})$

Инфляцын түвшин: Энэхүү индексд инфляцын түвшний сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийг тооцож ашигласан. Инфляцын түвшин нь улс бүрийн эдийн засгийн идэвхжил, мөн эрсдэлийг тооцоход чухал үзүүлэлт юм

5.2. Гадаад өр болон ДНБ-ийн харьцаа

$(\text{Нийт гадаад өр}) / (\text{ДНБ}) = (\text{Гадаад өр ДНБ-ний харьцаа})$

Улсын нийт гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь: Банкны системийн өсөлт хөгжилд тухайн улсын гадаад эрсдэл олон талаараа шууд нөлөөтэй юм. Улсын нийт гадаад өрийн үзүүлэлтээр макро эдийн засгийн эрсдэл, гадаад хүчин зүйлийг илэрхийлэгч голлох үзүүлэлтийн нэг билээ.

6-Р БҮЛЭГ:

Хүн амын хөгжлийн индекс

6.1. Худалдан авах чадварын тэнцлээр Нэг хүнд ногдох ДНБ

Дотоодын нийт бүтээгдэхүүний худалдан авах чадварын тэнцэл ашиглан ам.доллар луу шилжүүлэн тооцоолох

Нэг хүнд ноогдох ДНБ нь тухайн орны ДНБ-ийг нийт хүн амд хувааж тооцоолдог. Тухайн орны эдийн засгийн хөгжил, иргэдийн худалдан авах чадвар, хуримтлал үүсгэх боломж зэрэг банкны салбарт нэн шаардлагатай үзүүлэлтүүдийг энэ индексээр тодорхойлох бүрэн боломжтой.

6.2. Хүний хөгжлийн индекс

Хүний хөгжлийн индексийг тухайн орны газар зүйн байршил, дундаж наслалт болон дотоодын нийт орлогод тулгуурлан тооцдог

Энэхүү үзүүлэлт нь тухайн орны хөгжил, эдийн засгийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох суурь болж өгдөг учир банкны салбарын хөгжилд шууд болон шууд бусаар хамааралтай үзүүлэлт юм.

7-Р БҮЛЭГ:

Улс төрийн тогтвортой байдлын индекс

7.1. Бизнесийн таатай орчны индекс

Бизнесийн таатай орчны индексийг тухайн орны хууль эрх зүйн орчны дагуу бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардагдах хоногийн тусламжтайгаар тооцно.

Бизнесийн таатай орчны индекс нь тухайн оронд бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай байдлыг эрх зүй, дэд бүтэц болон санхүүгийн секторын хөгжил, аюулгүй байдлын түвшинд судлаж тогтоодог. Энэхүү индексийн тусламжтайгаар тухайн орны бизнесийн орчны аюулгүй байдлыг тодорхойлохоос гадна бизнес эхлүүлэх, маргаан шийдвэрлэх эрх зүйн орчин болон эдийн засгийн бусад үйл ажиллагааны бүтээмжийг урьдчилан тодорхойлох боломжтой. Иймд, бизнесийн таатай орчны индекс нь тухайн оронд үйл ажиллагаа явуулах гэж буй бизнес эрхлэгч бүрийн зайлшгүй авч үзэх шаардлагатай үзүүлэлт юм.

7.2. Авлигын индекс

13 өөр төрлийн авлигын талаарх судалгаан дээр үндэслэн тогтоодог.

Авлигын индекс нь тус орны төрийн байгууллагуудын авлигад автсан байдлыг тухайн

орны бизнес эрхлэгчид болон судалгааны байгууллагуудтай хамтран 13 төрлийн индикатор дээр үндэслэн тогтоодог.

Авлигын индексийн тусламжтайгаар бизнес эрхлэгчид нь тухайн оронд үйл ажиллагаа явуулахад хэр хүндрэлтэй байх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад тулгарах авлигал, хүнд суртлыг урьдчилан тодорхойлж өөрсдийн бизнесийн төлөвлөгөөнд энэхүү эрсдэлийг тооцоолох боломжтой болох юм.

7.3. Улс төрийн тогтвортой байдлын индекс

Улс төрийн тогтвортой байдлын индексийг тухайн оронд жилдээ гарч буй үймээн самуун, бослого, төрийн эргэлтийн тоог бусад орны мэдээлэлтэй харьцуулж гаргадаг.

Улс төрийн тогтвортой байдлын индекс нь тухайн оронд хууль бус замаар засгийн газрыг огцруулах, төрийн эргэлт хийх, хүчирхийлэл болон цэргийн хүчээр засгийн эрхийг авах гэх мэт эрсдлүүдийг тодорхойлдог. Энэхүү индекс нь банк санхүүгийн салбарт их хэмжээний эрсдэл дагуулах боломжтой ба тухайн орны хууль эрх зүйн орчин, мөнгөний бодлогод шууд нөлөөлөлтэй байдаг тул дээрх индексийг тооцоололд ашиглах зайлшгүй шаардлагатай.

8-Р БҮЛЭГ:

Мэдээллийн технологийн индекс

8.1. Нийт хүн амд эзлэх интернэт хэрэглэгчдийн тоо

(Нийт интернэт хэрэглэгчдийн тоо) / (Нийт хүн амын тоо) = (Нийт хүн амд эзлэх интернэт хэрэглэгчдийн тоо)

Хүн амын интернэт хэрэглээ нь банкны салбарын дижитал үйлчилгээг газар харгалзалгүй ашиглах боломжийг бүрдүүлдэг. Тиймээс тус үзүүлэлт нь онлайн банкны үйлчилгээг авах боломжийг тооцоолоход чухал үзүүлэлт билээ.

8.2. 100 хүн тутамд дахь гар утас эзэмшигчдийн тоо

(Нийт гар утас эзэмшигчдийн тоо) / (Нийт хүн амын тоо) * 100 = (100 хүн тутамд дахь эзлэх гар утас эзэмшигчдийн тоо)

Хүн амын гар утасны хэрэглээ нь банкны салбарын мобайл банкны үйлчилгээг газар харгалзалгүй ашиглах боломжийг бүрдүүлдэг. Тиймээс тус үзүүлэлт нь зайнаас банкны үйлчилгээг авах боломжийг тооцоолоход чухал үзүүлэлт билээ.

9.ИЖИЛ ТӨСТЭЙ ОРНУУДЫН БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ

КИРГИЗСТАН

- Банкны салбарт дижитал шилжилт, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний нөлөөгөөр сүүлийн жилүүдэд Киргизстан улсын банкны салбар тогтвортой өсөлттэй байна.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Киргизстан улсын санхүүгийн салбарт банкны салбарт давамгайлсан, хүүгийн түвшин ижил түвшний орлоготой улсуудтай харьцуулахад өндөр улсуудын нэг.

Тус улсын банкны салбар актив нь 2024 онд 32.8 хувиар өсөж, цэвэр ашгийн хэмжээ 2023 онтой харьцуулахад 28.5 хувиар нэмэгдсэн. Нийт банкны актив нь 2000 онд ДНБ-ийн 20% хувийг бүрдүүлж байсан бол 2024 онд 54%-ийг бүрдүүлж байна. Зээлийн бүтцийг харвал хэрэглээний зээл болон ипотекийн зээлийн өсөлт өндөр.

2024 оны байдлаар 21 арилжааны банк, 304 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Дундаж зээлийн хүү 19%-тай байгаа нь зээлийн эрсдэлийн зардал, эх үүсвэрийн долларжилт өндөр байгаатай холбоотой юм.

	2016	2020	2024
Банкны актив/ДНБ	19.9	30.1	53.5
Зээл /ДНБ	21.9	25.0	22.4
Хадгаламж/ДНБ	19.9	26.9	38.9
Бодлогын хүү	10	10	9
Зээлийн хүү	24.5	17.0	19.0
Хадгаламжийн хүү	2.4	1.4	3.5

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:


Чанаргүйдэл: 2024 онд зээлийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ 10.8% байна. Худалдаа, ХАА-н салбарт олгосон зээлийн чанаргүйдэл бусад салбаруудтай харьцуулахад өндөр байна.

Хөрвөх чадварын харьцаа: Төв банкны шаардлагын дагуу хөрвөх чадварын харьцааны доод хязгаар 45% боловч 2024 онд 73.1% байна.


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаар 12% боловч 2024 онд 22% байна.




ROA



ROE



NPL RATIO



КАЗАХСТАН

- Банкны салбарт дижитал шилжилт хийх, инновацыг нэвтрүүлэхээс гадна, хууль эрх зүйн томоохон өөрчлөлтүүдийг сүүлийн жилүүдэд эрчимтэй хийсэн нь банкны салбарын өсөлтөд эергээр нөлөөлж байна.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Казахстаны банкны салбар сүүлийн жилүүдэд чанаргүй зээлийн түвшинг бууруулах зорилгоор банкнуудын нэгтгэл, чанарын шинэчлэл хийх бодлого хэрэгжүүлж, активын чанар сайжирсан

Тус улсын банкны салбар актив нь 2024 онд 20.4 хувиар өсөж, ДНБ-ний 44 хувьтай тэнцэх хэмжээний активтай болсон. Банкнууд финтекийг эрчимтэй нэвтрүүлж, дижитал шилжилт хийж байгаа бөгөөд харилцагчдад хүрэх үйлчилгээний чанар, үр ашгаа нэмэгдүүлэхэд технологид ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна.

2024 оны байдлаар 21 арилжааны банк, гадаадын 11 банк тус улсад үйл ажиллагаа эрхэлж байна. Дундаж зээлийн хүү 17.1%-тай байгаа нь зээлийн эрсдэлийн зардал өндөр, гадаад нөхцөл байдал таагүй байгаатай холбоотойгоор Төв банк нь хүүгээ өсгөсөн нь нөлөөлжээ.

Сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, гадаад харилцааг сайжруулахад ихээхэн анхаарал хандуулж байна.




	2016	2020	2024
Банкны актив/ДНБ	52.7	49.0	45.9
Зээл /ДНБ	36.5	25.0	24.6
Хадгаламж/ДНБ	41.5	36.0	18.3
Бодлогын хүү	12.0	9.0	15.3
Зээлийн хүү	13.5	14.9	17.1
Хадгаламжийн хүү	9.0	9.2	13.2

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Чанаргүйдэл: 2024 онд зээлийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ 3.05% байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн зээл олголт нэмэгдсэн нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээг буурахад нөлөөлсөн. Дээр нь чанаргүй зээлийг бууруулахтай холбоотой хууль, эрх зүйн арга хэмжээг эрчимтэй авч байна.

Хөрвөх чадварын харьцаа: Төв банкны шаардлагын дагуу хөрвөх чадварын харьцааны доод хязгаар 59% боловч 2024 онд 78.9% байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаар 19.4% боловч 2024 онд 20% байна.



УЗБЕКИСТАН

- Узбекистан улсын банкны салбар 2016 оноос эхлэн төрийн оролцоог бууруулж, банкны үйл ажиллагааг зах зээлийн зарчимд шилжүүлэх реформыг эрчимтэй хэрэгжүүлж байна. Ялангуяа, хувьцаа эзэмшигч болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад ихээхэн анхаарал хандуулах болсон.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Дижитал банкны үйлчилгээний нэвтрэлт түргэн өсөж байгаа ч, санхүүгийн дэд бүтцийн хөгжил бүс нутгийн бусад оронтой харьцуулахад дундаж түвшинд хэвээр байна.

Тус улсын банкны салбар актив нь 2024 онд 35 хувиар өсөж, ДНБ-ний 53 хувьтай тэнцэх хэмжээний активтай болсон. Банкнууд нь хувьцаа эзэмшигчийн тоог нэмэгдүүлэх, зээлийн өсөлтийг хадгалах, эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг эрчимтэй авч байна.

2024 оны байдлаар 31 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаагаас 17 нь томоохон ангилалд багтаж буй бол үлдсэн 14 нь жижиг банк гэсэн ангилалд багтдаг.

Дундаж зээлийн хүү 23.4%-тай байгаа нь зээлийн эрсдэлийн зардал өндөр, гадаад нөхцөл байдал таагүй байгаатай холбоотойгоор Төв банк нь хүүгээ өсгөсөн нь нөлөөлжээ.





	2016	2020	2024
Банкны актив/ДНБ	19.8	52.5	52.9
Зээл /ДНБ	21.8	40.5	36.7
Хадгаламж/ДНБ	15	16	21
Бодлогын хүү	8	14	13.5
Зээлийн хүү	13.5	18.8	23.4
Хадгаламжийн хүү	14.75	14.8	19.7

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Чанаргүйдэл: 2024 онд зээлийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ 4.3% байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн зээл олголт нэмэгдсэн нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээг буурахад нөлөөлсөн.

Хөрвөх чадварын харьцаа: Төв банкны шаардлагын дагуу хөрвөх чадварын харьцааны доод хязгаар 100% боловч 2024 онд 116.9% байна. Бусад улсуудтай харьцуулахад хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн шаардлага хэт өндөр байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаар 17.3% боловч 2024 онд 17.4% байна.



ИНДОНЕЗ

- Индонез улсын банкны салбарын дижитал хөгжил эрчимжиж, банкнуудын интернэтийн хэрэглээ өсөж байгаатай холбоотойгоор дижитал платформ, мобайл үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэх зорилгоор засгийн газрын зүгээс банкны салбарын дижитал шилжилтийг эрчимтэй дэмжиж ажиллаж байна.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд финтек салбарын зохицуулалтыг сайжруулж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хяналтын механизмуудыг чангатгаж эхлээд байна.

Тус улсын банкны салбар актив нь 2024 онд 6 хувиар өсөж, ДНБ-ний 51 хувьтай тэнцэх хэмжээний активтай болсон. Сүүлийн жилүүдэд чанаргүй зээлийн хэмжээг бууруулахад ихээхэн анхаарлаа хандуулж хууль, эрх зүйн шинэчлэлийг эрчимтэй хийж байна.

2024 оны байдлаар арилжааны, орон нутгийн болон ислам шашны гэсэн 100 банк үйл ажиллагаа явуулдаг. Банкны салбарын өрсөлдөөн бусад улсуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

Дундаж зээлийн хүү 8.62%-тай байгаа нь өмнө нь танилцуулсан 3 улстай харьцуулахад нам дор түвшинд байна.




	2016	2020	2024
Банкны актив/ДНБ	52.7	72.0	51.5
Зээл /ДНБ	36.5	31.4	35.4
Хадгаламж/ДНБ	41.5	43.2	32.6
Бодлогын хүү	4.8	5.8	5.8
Зээлийн хүү	11.4	9.5	8.6
Хадгаламжийн хүү	6.0	5.5	5.0

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Чанаргүйдэл: 2024 онд зээлийн багц дахь чанаргүй зээлийн хэмжээ 2.08% байна. Цар тахлын дараа авч буй арга хэмжээнүүд, зээлийн эрсдэлийн менежментийг эрчимтэй авсан зэрэг нь чанаргүй зээл нам дор түвшинд байхад нөлөөлж байна.

Хөрвөх чадварын харьцаа: Төв банкны шаардлагын дагуу хөрвөх чадварын харьцааны доод хязгаар 87.5% бол 2024 онд банкнуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт 113.6%-д хүрчээ.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаар 26.69% түвшнийг банкнууд барьж ажиллаж байна.



10.МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР


Дэлхийн өрсөлдөх чадварын төв /IMD/-өөс улсуудын Өрсөлдөх чадварын индексийг жил бүр тооцон гаргадаг. Энэхүү индекс нь эдийн засгийн үзүүлэлт, засгийн газрын үр ашигтай байдал, бизнесийн үр ашигтай байдал, дэд бүтэц гэсэн үндсэн 4 бүлгээс бүрдэх бөгөөд бүлэг тус бүр нь 5 дэд хувьсагчийг өөртөө агуулдаг.

Монгол Улсын хувьд 2024 онд тус индексийн тооцоололд хамрагдсан 67 улсаас 61-р байранд бичигджээ. Өмнөх онтой харьцуулахад 1 байраар урагшилжээ.

Эдийн засгийн индексээр 2024 онд 67 орноос 42-т бичигдэж өмнөх оноос 18 байраар урагшилсан байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт тогтвортой, инфляц аажмаар буурсан нь эергээр нөлөөлсөн. Харин гадаадын хөрөнгө оруулалт дорвитой нэмэгдээгүй, гадаад худалдааны төрөлжилт бага, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь индексийн утгад сөргөөр нөлөөлжээ.

Засгийн газрын үр ашигтай байдлын индексээр 2024 онд 67 орноос 53-д эрэмбэлэгдэж өмнөх оноос 5 байр урагшилсан байна. Татварын бодлого, нийгмийн санхүүжилтийн хувьд харьцангуй тогтвортой байгаа нь индексийн утгад эергээр нөлөөлсөн бол бизнесийн таатай орчныг бүрдүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, нийгмийн болон институтыг дэмжих тал дээр сулхан ажилласан нь индексийн утгад сөргөөр нөлөөлжээ.

Өрсөлдөх чадварын ранк /67 орноос/



Эх сурвалж: IMD

Бизнесийн үр ашигт байдлын индексээр 2024 онд 62-д жагсаж өмнөх оноос 2 байр дээшилсэн байна. Манай улсын хувьд хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал, бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүжилт болон бизнес эрхлэгчдийн менежмент засаглал дорвитой сайжрахгүй байгаа нь индексийн утгад сөргөөр нөлөөлж байна.

Дэд бүтцийн индексээр манай улс 2024 онд 67 орноос 64-д эрэмбэлэгдэж өмнөх жилээс 1 байр ухарсан байна. Манай улсын хувь шинжлэх ухааныг дэмжсэн, технологийн дэвшлийг дэмжсэн дэд бүтцийн хөгжил харьцангуй муу байна. Дээр нь байгаль орчин, эрүүл мэнд, боловсролыг дэмжсэн дэд бүтцүүд сайжрахгүй байгаа нь индексийн утгад сөргөөр нөлөөлжээ.

Монгол Улсын хувьд 2025 онд дараах сорилтууд тулгарахаар байна. Үүнд:

- Төсвийн хэт их тэлэлт, популист амлалтаас үүдэлтэйгээр мөнгөний нийлүүлэлт үргэлжилж инфляц нэмэгдэх.
- Төсөвт тусгасан олон төрлийн төслүүд, цалин болон тэтгэврийн өсөлт нь валютын ханшид дарамт учруулах.
- Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний үнэ болон тоо хэмжээний бууралт нь экспортын орлогод нөлөөлөх, цаашлаад эдийн засгийн өсөлтийг хадгалахад хүндрэл учруулах.
- Агаарын бохирдол, хөрсний бохирдлыг бууруулах, суурь дэд бүтцүүдийг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг эрчимтэй авахгүй бол эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг улам бүр хязгаарлаж байна.
- АНУ болон Хятад улсын хоорондох худалдааны дайн, Орос болон Хятадын хоорондох геополитикийн асуудал хурцдах нь манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байгаа тул цаашид хэрхэн энэхүү хүндрэлийг даван туулах тал дээр анхаарлаа хандуулж, стратегийг боловсруулах хэрэгцээ өндөр байна.

11.БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ



Банкны салбар нь 2004 оноос хойш жилд дунджаар 24%-ийн өсөлттэй байна. Банкны салбарын өсөлтөд уул уурхайг дагасан эдийн засгийн мөчлөг, төрөөс хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд ихээхэн нөлөөлжээ. Сүүлийн 4 жилийн хугацаанд технологийн дэвшил, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг банкнууд эрчимтэй хөгжүүлж хэрэглэгчдэд хурдан шуурхай, хялбар санхүүгийн үйлчилгээг хүргэхэд ихээхэн дэвшил гаргалаа.

Энэхүү хэсэгт банкны салбарын 2019 оны санхүүгийн голлох үзүүлэлтийг 2025 онтой харьцуулан тайлбарлахыг зорилоо. Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтийг нийлмэл жилийн өсөлтийн хувь (CAGR)-р харуулах нь хөрөнгө оруулагчдад тус салбар нь хэрхэн үр ашигтай тогтвортой өсөж буйг харуулах чухал ач холбогдолтой гэж үзсэн.


Банкны салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2019 онд 7%-тай байсан бол 2024 онд 24%-тай гарсан нь дэлхийн дунджаас 2 дахин их байна. Оны эхнээс зээл олголт нэмэгдэж тэр хэмжээгээр зээлийн хүүгийн орлого өссөн нь өөрийн хөрөнгийн өгөөж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Банкны салбарын “Шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020-2023 оны хооронд хэрэгжүүлсэн. Хөтөлбөр нь 1) Банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадварыг сайжруулах, 2) Олон нийтийн өмчид шилжих замаар банкнуудад тавих хөндлөнгийн хяналтыг нэвтрүүлж, үйл ажиллагааг ил тод байлгах, зохистой засаглалыг буй болгоход чиглэсэн.

Тус хөтөлбөрийн хүрээнд системийн нөлөө бүхий банкнууд 2022 оноос эхлэн олон нийтэд хувьцаагаа санал болгож нээлттэй компани болох замаар өөрийн хөрөнгийн хэмжээг 447 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн. Дээр нь сүүлийн жилүүдэд технологийн тусламжтайгаар ажилчдын бүтээмжийг дээшлүүлж хэрэглэгчдэд хурдан шуурхай, хялбар үйлчилгээг санал болгож буй нь зардлын үр ашигтай байдлыг нэмэгдүүлжээ.

Нийт хөрөнгийн өгөөж 2019 онд 0.7% байсан бөгөөд тухайн үед эдийн засгийн салбарууд агшиж түүнийг дагаад банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж эхэлсэн нь зээлийн эрсдэлийн зардлыг өсгөсөн. Дээр нь үйл ажиллагааны зардал их, хүүгийн маржин доогуур байсны улмаас нийт хөрөнгийг үр ашигтай ашиглалт харьцангуй доогуур байжээ.

Банкны салбар сүүлийн 5 жилийн хугацаанд үр ашигтай, тогтвортой өсөлттэй ажиллаж санхүүгийн зах зээлд чухал үүрэг гүйцэтгэж байна.



Эх сурвалж: Банкны секторын тойм-2024, Банк санхүүгийн академи

Харин 2024 оны байдлаар харахад нийт хөрөнгийн өгөөж нь 2.1%-д хүрчээ. Ийнхүү нийт хөрөнгийн өгөөж нэмэгдэхэд 2021 оноос эхлэн цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийн зээл болон өөрийн эх үүсвэрээр олгох зээл тогтмол нэмэгдсэн нь хүүгийн орлогыг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн.

Дээр нь банкнууд технологийн шинэчлэлийг эрчимтэй хийж технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар хийх боломжийг бүрдүүлсэн нь хүүгийн бус орлогыг өсөлтийг буй болголоо. Ийнхүү үйл ажиллагааны орлогын хөрөнгөд харьцуулсан хувь хэмжээ 2019 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдэж 10%-д хүрчээ.

2019 онд хүүгийн бус орлогын 40% нь зардалд зарцуулагддаг байсан бол технологийн шийдлийг үйл ажиллагаандаа идэвхтэй ашигласнаар ажилчдын бүтээмж нэмэгдэхийн зэрэгцээ үйл ажиллагааны зардал буурч 2024 онд хүүгийн бус орлогын 25% нь үйл ажиллагааны зардалд ашиглагдаж байна. Ийнхүү зардлын CAGR 10% байна.

Эдийн засгийн салбарууд 2019 оны эхнээс эхлэн агшиж тэр хэмжээгээр бизнесийн зээлийн чанаргүйдэл нэмэгдсэн нь банкны салбарын эрсдэлийн зардлыг нэмэгдүүлж байсан бол 2022 оноос эхлэн эдийн засгийн салбарууд идэвхжихийн хэрээр бизнесийн зээлийн чанаргүйдэл буурч эхэлсэн нь эрсдэлийн зардлыг буурахад чухал хувь нэмэр оруулсан. Нөгөө талаас олон нийтэд нээлттэй болохтой холбоотойгоор активын чанарын үнэлгээг хийж зээлийн эрсдэлтэй холбоотой менежментийг оновчтой хэрэгжүүлж активын чанарыг сайжруулсан. 2024 оны эцэст чанаргүй зээлийн хэмжээ 5%-д хүрсэн нь сүүлийн 15 жилийн хамгийн доод түвшиндээ хүрсэн.

Үйл ажиллагааны орлого өсөж, эрсдэлийн зардал буурах нь банкнуудын өөрийн хөрөнгийн ашиглалт нэмэгдэхийн хэрээр банкнуудын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдэж жил бүр улсад төлж буй татварын хэмжээ тогтмол өссөн байна. Банкнуудын хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэмд тустай үйл ажиллагаа эрхлэх, энэ чиглэлд хөрөнгө оруулах сонирхол жил ирэх тутам нэмэгдэж байна.

Банкнуудын төлж буй татварын хэмжээ 2019 онд татварын өмнөх ашгийн 24%-тай тэнцэж байсан бол 2024 онд 37%-тай тэнцэх болжээ.

Банкны салбар нь өөрийн 1 төгрөгийг ашиглан 10 төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл, хөрөнгө оруулалт болон бусад төрлийн үр ашигтай үйл ажиллагаанд хөшүүрэг байдлаар ашиглаж байна. Хөшүүргийг 2019 онтой харьцуулахад нийлмэл жилийн өсөлтийн хувь 1% байгаа нь харьцангуй бага үзүүлэлт хэдий ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн мөчлөгийн үе таарсан, зээлийн эрэлт 2020, 2021 онуудад бага байсан, дээр нь учирч болзошгүй эрсдэлтэй холбоотойгоор зохицуулалтын орчин чангарсан зэрэг нь ихэвчлэн нөлөөлжээ.

Системийн нөлөө бүхий банкнууд 2022 оноос эхлэн хөрөнгийн зах зээлд нээлттэй болсноор хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээг 2021 онтой харьцуулахад 102% орчим хувиар нэмэгдүүлэхээс гадна хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 48%-ийг дангаар бүрдүүлж байна. Мөн хөрөнгийн зах зээлийн өдрийн арилжааны 50-60%-ийг дангаараа бүрүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулаа.

Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой, өөрийн хөрөнгийн өгөөж сүүлийн 3 жилийн хугацаанд 20% орчимд хадгалагдаж буй хэдий ч хөрөнгийн биржид бүртгэлтэй худалдаа, үйлдвэрлэл, тээвэр логистикийн салбарын компаниудтай харьцуулахад хувьцааны P/B харьцаа нь доогуур буюу дээрх салбаруудтай харьцуулахад илүү хямдхан хямдхан байгааг илтгэж байна.

Манай улсын хөрөнгийн зах зээлд оролцогчийн бүтцийг харахад гадаадын хөрөнгө оруулагчид бага, багцын хөрөнгө оруулалт хараахан хөгжөөгүй ихэвчлэн жижиг хөрөнгө оруулагчид байна. Иймд банкны салбарын ашигт ажиллагаа, засаглалын тогтолцоо, өрсөлдөх чадвар бүс нутагт харьцангуй өндөр байгаа талаар мэдээлэл дутмаг байна. Иймд банкнууд хөрөнгө оруулагчдад ашигт ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаар тогтмол мэдээлэх, хөрөнгө оруулагчидтай харилцааг сайжруулахаас гадна өөрийн активын чанарыг хэрхэн сайжруулж байгаа талаар хөрөнгө оруулагч нарт тохирсон мэдээллийг тогтмол өгч байх шаардлагатай.